



АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. ОРШИЛ.....	3
1.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХИЙЛГЭХ ҮНДЭСЛЭЛ	3
1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО.....	4
1.4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ.....	4
1.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ БАГ.....	4
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	5
2.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ	7
2.3. СТАНЦЫН ТЕХНОЛОГИ.....	7
2.3.1. Дулааны станцын өнөөгийн технологи.....	7
2.4. ҮЙЛДВЭРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	8
2.5. ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР АШИГЛАЛТ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХИЙЦ, МАТЕРИАЛ.....	9
2.6. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ.....	9
2.6.1. Цахилгаан хангамжийн эх үүсвэр.....	9
2.6.2. Усан хангамжийн эх үүсвэр.....	11
2.6.3. Төмөр зам, автозам.....	12
2.7. ХОГ ХАЯГДАЛ	12
БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	15
3.1. УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ.....	15
3.2. АГААРЫН ЧАНАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	16
3.3. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ, ГЕОМОРФОЛОГИ	16
3.4. ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС	19
3.4.1. Гадаргын усны сүлжээ, онцлог	19
3.4.2. Газрын доорх ус	21
3.5. ХӨРСӨН БҮРХЭВЧ.....	22
3.6. УРГАМЛАН НӨМРӨГ.....	23
3.7. АМЬТНЫ АЙМАГ	24
БҮЛЭГ 4. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	25
4.1. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ЭРЧИМ	25
4.2. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ.....	27
4.3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ.....	29
4.4. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙ, ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ.....	30
4.5. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ.....	30
4.6. ТӨСЛӨӨС АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ.....	30
4.7. ТӨСЛӨӨС ОРШИН СУУГЧДАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ	31
БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	32
5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	32
5.2. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	33
5.3. НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	39
5.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	39
5.5. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 39	
5.6. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	40
5.7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	42
5.8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	43
5.9. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	45



**“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “ АМГАЛАН
ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 6. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	48
БҮЛЭГ 7. ХУУЛЬ ТОГТООМЖ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	49
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	52



БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА

1.1. ОРШИЛ

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ийн Амгалан дулааны станц төсөл нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байна.

Улаанбаатар хотын Амгалан дулааны станцын одоогийн 3х116МВт суурилагдсан хүчин чадлыг 1х116МВт -аар дулаан үйлдвэрлэх нэг блокоор өргөтгөнө.

Тус дулааны станц нь Багануур, Шивээ-Овоо, Алагтолгойн нүүрсээр дулааны эрчим хүч үйлдвэрлэх зориулалт бүхий дулаан эрчим хүчний үйлдвэр бөгөөд цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ “Амгалан” 110/10кВ-ийн дэд станцаас 110 кВ-ын агаарын шугам дамжуулан “Дулаан” дэд станцын 110/10кВ-ын 2х20МВт-ын хүчин чадал бүхий трансформартортой 10 кВ хүртэл бууруулан дотоод хэрэгцээндээ ашиглаж байна.

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний “Экологийн бүтээмж” ХХК боловсруулсан ба тус тайланг Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”, Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан гүйцэтгэсэн юм.

“Байгаль орчны хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ тухай” Монгол улсын хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”, БОАЖЯ-ны ерөнхий шинжээчийн 2018 оны 09 сарын 20 өдрийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний 2018/NA004 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлт зэргийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот сайдын тушаал Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлалын дагуу хийж гүйцэтгэв.

1.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХИЙЛГЭХ ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухайн хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан.

Тус төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг 2022 онд “Дэлгэр консалтинг” ХХК хийж гүйцэтгэсэн байна.



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БОННУ-ний эрх бүхий “Дэлгэр консалтинг” ХХК нь “Амгалан дулааны станц” ТӨХК - ний 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот сайдын тушаалуудыг үндэслэн боловсруулав.

1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

“Амгалан дулааны станц” ТӨХК-ний байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 2023 онд хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, нийгмийн асуудал, байгаль орчин, тухайн хороонд ажиллаж амьдрах иргэдийн харилцаа хариуцсан нэгж хэсгүүдийн хамтын ажиллагааг хангасан удирдлага зохион байгуулалтын механизмыг бүрэлдүүлж, хэрэгжүүлэхэд ашиглагдах баримт бичиг юм.

1.4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний аргачлал, Эрсдлийн үнэлгээ, Эрүүл мэндийн эрсдлийн тухай, Монгол улсын хууль тогтоомж, Байгаль орчны багц хуулиуд, Монгол улсын стандарт норм, дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэв.

Энэхүү төлөвлөгөө нь:

- ✓ Товч танилцуулга, байгаль орчны төлөв байдал, үйлдвэрийн өнөөгийн байдал
- ✓ Дулааны цахилгаан станцад үүсэх нөлөөллийн үнэлгээ
- ✓ Дулааны цахилгаан станцын үйл ажиллагааны явцад үүсэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- ✓ Төслийн хэрэгжилтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний зардал
- ✓ Байгаль орчин, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого ба журам гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

1.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ БАГ

БОННУ, БОМТ-г хийж, бэлтгэх ажлыг байгаль орчны зөвлөх, экспертизийн “Дэлгэр консалтинг” ХХК төсөл хэрэгжүүлэгч “Амгалан дулааны станц” ТӨХК-тай хамтран амжилттай хийж гүйцэтгэв.



БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: Амгалан дулааны станцыг 1х116МВт хүчин чадал бүхий зуухаар өргөтгөх төсөл

Төслийн зорилго: Төсөл хэрэгжүүлэгчийн үндсэн зорилго нь “*Орчин үеийн дэвшилтэт технологиор эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангах*”-д орших бөгөөд цаашид Амгалангийн дулааны станцын техник-эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өөрийн өргийг хямдруулах, жилийн 4 улирал тасралтгүй ажиллуулах, дулаан цахилгаан хослон үйлдвэрлэх, Улаанбаатар хотын хэрэглэгчдийг тасралтгүй найдвартай эрчим хүчээр хангах, Улаанбаатар хотын зүүн хэсгийн дулааны өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хаах зорилтуудыг тавин төслийг хэрэгжүүлж байна.

Төсөл хэрэгжүүлэгчийн тухай мэдээлэл

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн тухай мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр	“Амгалан дулааны станц” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011573097
Регистрийн дугаар	6021646
Улсад бүртгүүлсэн	2015.11.19
Үйл ажиллагааны чиглэл	Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хангах, түгээх, худалдах
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15 1-1 тоот, өөрийн байр
Утас	(+976) 7711-1252
Факс	(+976) 77111253
Вэбсайт	http://ahp.energy.mn

Төслийн байршил:

Амгалан дулааны станц нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн өөрийн байранд байрладаг байна.


Хүснэгт 2. Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол

№	X	Y	Цэг	Урт	№	X	Y	Цэг	Урт
1	5310815.96	650098.89	1-2	2.18	19	5311101.03	649694.30	19-20	5.04
2	5310813.79	650099.12	2-3	146.43	20	5311105.96	649693.24	20-21	30.98
3	5310808.48	649952.79	3-4	183.63	21	5311136.25	649686.76	21-22	0.52
4	5310807.31	649769.16	4-5	3.11	22	5311136.48	649687.23	22-23	38.88
5	5310810.41	649768.93	5-6	116.03	23	5311146.06	649724.91	23-24	18.23
6	5310926.43	649770.01	6-7	23.74	24	5311151.27	649742.38	24-25	170.33
7	5310950.17	649770.38	7-8	23.92	25	5311199.19	649905.83	25-26	92.76
8	5310974.09	649770.71	8-9	33.66	26	5311192.45	649998.34	26-27	59.57
9	5311007.75	649770.39	9-10	19.03	27	5311132.92	650000.56	27-28	8.15
10	5311019.43	649755.36	10-11	3.33	28	5311134.12	650008.62	28-29	47.02
11	5311022.76	649755.41	11-12	13.10	29	5311087.48	650014.6	29-30	176.44
12	5311023.35	649742.32	12-13	9.25	30	5310912.47	650037.04	30-31	11.54
13	5311023.28	649733.07	13-14	24.66	31	5310903.07	650043.74	31-32	26.71
14	5311047.91	649731.95	14-15	25.01	32	5310882.39	650060.64	32-33	18.83
15	5311072.89	649730.72	15-16	0.04	33	5310866.34	650070.48	33-34	9.94
16	5311072.93	649730.72	16-17	30.90	34	5310857.51	650075.04	34-35	34.93
17	5311071.59	649699.85	17-18	23.39	35	5310827.34	650092.64	35-36	12.98



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ
 “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВТ ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ”
 ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 8-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ АМГАЛАН
 ДУЛААНЫ СТАНЦЫН БАЙРШЛЫН ТОЙМ ЗУРАГ**



Таних тэмдэг

- Дулааны станцын байршил
- Дулааны станцын талбай
- Дүүргийн хил

Зургийн эхийг бэлтгэсэн: "ЭКОЛОГИЙН БҮТЭЭМЖ" ХХК-ний
 Байгаль орчны зайнаас тандан судлалын мэргэжлэтэн Ц.Нурбахыт
 Улаанбаатар хот 2019.05.15

Зураг 1. Төслийн байршлын тойм зураг





2.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Улаанбаатар хотын Амгалан дулааны станцын одоогийн 3х116МВт суурилагдсан хүчин чадлыг 1х116МВт -аар дулаан үйлдвэрлэх нэг блокоор өргөтгөнө.

Тус дулааны станц нь Багануур, Шивээ-Овоо, Алагтолгойн нүүрсээр дулааны эрчим хүч үйлдвэрлэх зориулалт бүхий дулаан эрчим хүчний үйлдвэр бөгөөд цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ “Амгалан” 110/10кВ-ийн дэд станцаас 110 кВ-ын агаарын шугам дамжуулан “Дулаан” дэд станцын 110/10кВ-ын 2х20МВт-ын хүчин чадал бүхий трансформатортай 10 кВ хүртэл бууруулан дотоод хэрэгцээндээ ашиглаж байна.

Үйлдвэрлэлийн ажилчид, албан хаагчид, ажиллах горим

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг баталсан. Тус станц нь одоогийн байдлаар үндсэн үйлдвэрлэлийн 7 (Зуухан цех, Түлш дамжуулах цех, Хими хэсэг, Цахилгааны хэсэг, ДХХА-ийн хэсэг, Авто хэсэг, Үйлдвэрлэлийн програм хангамжийн хэсэг) үйлдвэрлэлийн бус (Захиргаа, удирдлагын хэлтэс, Санхүү эдийн засгийн хэлтэс, ААХҮАлба) гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус станцад одоогийн байдлаар 180 ажилтан албан хаагч ажиллаж байгаа бөгөөд цаашид ерөнхий удирдлага-4, станцын ИТА-16, захиргаа-4, санхүү-3, блокын цех- 34, түлш дамжуулах, ус боловсруулах цех-12, цахилгаан, КИП-А-16, авто аж ахуй, механик цех-12, хангамж-1, бусад-7 ажилтан албан хаагч ажиллах зохион байгуулалттай ажиллана.

2.3. СТАНЦЫН ТЕХНОЛОГИ

2.3.1. Дулааны станцын өнөөгийн технологи

Станцад эргэлдэгч буцламтгай үет шаталттай усан халаагуурын зуухыг ашигладаг бөгөөд шаталтанд шаардлагатай нүүрс нь зуух тус бүрт байрлах нүүрсний бункераас нүүрсний жингээр жинлэгдэн зуухны галын хотолд өгөгдөнө. Анхдагч агаарын салхилуураар шахагдсан агаар нь агаар халаагчаар дамжин халж ихэнх нь галын хотлын доод хэсэгт байрлах агаарын сувгууд руу зөөгдөх ба үлдсэн халуун агаар нь галын хотлын хэсэгт өгөгдөнө. Анхдагч агаар халаагчаас гарсан халуун агаарын нэг хэсэг нь буцаж анхдагч агаарын сорох тал руу өгөгдөх схемтэй. Зуух тус бүрт анхдагч агаарын салхилуур суурилуулна.

Зуух тус бүрт хоёрдогч агаарын салхилуур суурилуулах ба хоёрдогч агаарын салхилуураар шахагдан агаар нь агаар халаагчаар халаагдан зуухны галын хотолд өгөгдөнө.

Шаталтаас үүссэн халуун утааны хий нь зуух тус бүрд байрлуулсан утаа сорогчоор сорогдон галын хотлын халах гадаргуу, экономайзер, агаар халаагчаар дамжин дулаанаа өгөх бөгөөд үнс барих төхөөрөмжөөр дамжин утааны хийд агуулагдах үнсний жижиг хэсгүүд баригдан, утаа сорогчоор шахагдан зуухны янданд орж атмосферын агаарт хаягдана.

Сүлжээний усны буцах шугамд тавигдсан сүлжээний усны насосоор шахагдсан ус нь эргэлдэгч буцламтгай үет шаталттай зууханд орж халсан ус нь сүлжээний усны өгөх шугамд орно. 4 ширхэг сүлжээний усны насос суурилуулах ба 1 нь нөөцөнд байна.

Цэвэрлэх байгууламжаас гарсан нэмэлт ус нь зуух руу орох ерөнхий шугамд



холбогдоно. 2 ширхэг давтамж хувьсгуур бүхий цэвэрлэгээний усны суурилуулна. Дулааны шугам сүлжээнд тогтмол даралт үүсгэхийн тулд сүлжээний усны насосны даралтын горимыг барьж ажиллана.

2.4. ҮЙЛДВЭРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Одоо ашиглагдаж буй тоног төхөөрөмж: Амгалан дулааны станцад одоогийн байдлаар 1075 нэр төрлийн 1691 ш тоног төхөөрөмжтэй ажиллаж байна.

Цаашид нэмж ашиглагдах тоног төхөөрөмж: Амгалангийн дулааны станцыг 50МВт-ын нэг блокоор өргөтгөх ТЭЗҮ-ийн Эцсийн тайланд тусгагдсан үндсэн болон туслах тоноглолын техникийн үзүүлэлтэнд заагдсан хүчин чадлын дагуу “Зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж үйлдвэрлэх, нийлүүлэх, угсрах, туршилт тохируулга хийх, хүлээлгэн өгөх” зэрэг бүх ажлууд түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр ЕРС гүйцэтгэгчийн гэрээний ажлын эзэлхүүнд орно. Үүнд:

- **Зуух:** 220 т/ц уур боловсруулах эргэлтэд буцламтгай үет шаталттай нэг иж бүрдэл зуух, зуухны туслах тоноглол, шугам хоолой, өрлөг, дулаалга, шат тавцан, галын хотлын дотор талын үрэлтээс хамгаалах хамгаалалт, галлагааны систем, шингэн түлшний бак, өргөх зөөх механизм, үндсэн барилгын хамт;
- **Турбин:** 40МВт/56гкалц–ийн цахилгаан/дулаан хослон үйлдвэрлэх (конденционы горимд 50МВт) нэг иж бүрдэл турбин, турбины туслах тоноглол, шугам хоолой, дулаалга, шат тавцан, тэжээлийн усны систем, дулаан хангамжийн тоног тоноглол, турбин заалны өргөх зөөх механизм, тос, тосолгооны систем цэвэрлэх төхөөрөмжийн хамт, конденсатор цэвэрлэх систем, үндсэн барилгын хамт;
- **Генератор:** 50МВт-ын суурилагдсан хүчин чадалтай, агаарын хөргөлттэй цахилгаан генератор нэг иж бүрдэл, туслах тоноглол, иж бүрэн хуваарилах байгууламжийн хамт;
- Эргэлтийн усны систем, хөргөх цамхаг нэг иж бүрдэл;
- Түлш дамжуулах систем. Одоо байгаа түлш дамжуулах системийг өргөтгөж нэмэлтээр нэг хос иж бүрдэл конвейер, бутлагч тавина. Одоо байгаа бутлуурыг сэргээн засварлах буюу солих, чичиргээт шигшүүрийг буулгаж зайлуулах, шинээр нүүрс хадгалах талбай, вагон гэгсгэгчийг иж бүрдлээр нь нийлүүлж, суурилуулах;
- Үнс, шаарга зайлуулах систем нэг иж бүрдэл;
- Шахсан агаарын систем түүний шугам хоолой, компрессорын хамт нэг иж бүрдэл;
- Одоо байгаа яндантай өргөтгөлийн зуухны утааны хийн хоолойг холбох;
- Шинэ дулааны шугам хоолой түүний тулгуур, татуурга, дулаалга, иж бүрдэл;
- Түүхий усны систем, усан сангийн иж бүрдэл;
- Хими, ус цэвэрлэгээ нэг иж бүрдэл туслах тоноглол, шугам хоолой, дулаалга, шат тавцан, бак, өргөтгөлийн барилгын хамт;
- Ус хангамжийн систем, гүний усны худагийн иж бүрдэл, шугам хоолой, дулаалга, тулгуур барилгын хамт;
- Насос станц иж бүрдэл шугам хоолой, дулаалга, хаалт арматур, барилгын хамт;
- Цахилгааны хэсэг нэг иж бүрдэл ил хуваарилах байгууламж, 110кВ-ын ЦДАШ-ын хамт;
- Оффисийн барилгын өргөтгөл, цайны газар, ажилчдын ахуйн байрны иж бүрэн цогцолбор;
- Хэмжүүр, автоматик, DCS удирдлагын систем станцын хэмжээнд нэг иж



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ “ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

бүрдэл, станцын удирдлагын нэгдсэн байр тоног төхөөрөмжийн иж бүрдэл, барилгын хамт;

- Холбоо, телемеханик, ТВ-ын дотоод суваг видео өнгөт дэлгэц, хяналтын камерийн хамт;
- Зуухнаас гарч байгаа хуурай үнсийг фракцаар ангилж 50кг-аар савлах төхөөрөмж нийлүүлэх, угсрах, хуурайгаар савласан үнсийг хадгалах байрны барилгын хамт;
- Түргэн элэгддэг тоноглолын эд анги, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх;
- Хими (нүүрс, тос, ус шинжлэх), цахилгаан, хэмжүүрийн лабораторын тус бүр нэг иж бүрдэл;
- Засвар механик цех тоног төхөөрөм (фрезер, огтлогч, хайч, өрөм, олон төрлийн эд анги зорогч суурин машин гэх мэт), барилгын хамт

2.5. ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР АШИГЛАЛТ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХИЙЦ, МАТЕРИАЛ

Нийт 106956.0м² талбайг хамрах ба уг нэгж талбарт хими цех 896.4м², нүүрс бутлах байгууламж 330.75м², оффис 432м², станцын үндсэн барилга 2844м², сэнсний байгууламж 464.4м², 10квт-ын цахилгааны дэд өртөө 678.6м², вагоны чингэлэг суллах байгууламж 420м² талбайг эзэлж байна.

Хүснэгт 3. Объект болон зам талбайн хэмжээ

№	Объектийн нэр	Урт	Өргөн	Нийт хэмжээ (квм)
1	Хими цех	49.8	18.0	896.4
2	Нүүрс бутлах байгууламж	24.5	13.5	330.75
3	Оффис	30.0	14.4	432.0
4	Станцын үндсэн байгууламж	72.0	39.5	2844.0
5	Сэнсний байгууламж	51.6	9.0	464.4
6	10квт-ын цахилгааны дэд өртөө	34.8	19.5	678.6
7	Вагоны чингэлэг суллах байгууламж	15.0	28.0	420.0
8	Нийт			6066.15

2.6. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

2.6.1. Цахилгаан хангамжийн эх үүсвэр

Амгалан дулааны станцын дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хангамжид 110/35/10кВ-ын “Амгалан” дэд станцын өндөр талын 110кВ-ын ЦДАШ-аас 2 хэлхээт 110кВ-ын шугам татан өөрийн дэд станцад суурилагдсан нэг бүр нь 20МВт-ын хүчин чадалтай, SZ11-20000/110 марктай хүчний 2 ширхэг трансформаторыг тэжээн ашиглаж байна. Трансформаторууд нь ээлжлэн ажиллах зориулалттай бөгөөд одоогоор 1-р трансформатор ашиглалтад, 2-р трансформатор нөөцөнд байна. Тус трансформаторууд нь Хятад улсад үйлдвэрлэгдэж байгаа сүүлийн үеийн технологийн дагуу үйлдвэрлэгдсэн алдагдлын хэмжээ багатай тоноглол юм. Трансформаторын суурилагдсан хүчин чадлын ашиглалт 25-30 хувь буюу ойролцоогоор 4.5-6МВт орчим чадлаар ачаалагдаж байна.



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВТ ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 2. ЦЭХ-ий хэрэглээ




Зураг 3. Нэгж дулаанд зарцуулсан ЦЭХ

Зураг 2-д харуулсан нэгж дулаан үйлдвэрлэхэд зарцуулагдсан ЦЭХ-ий хэмжээний графикаас сүүлийн жилүүдийн ЦЭХ зарцуулалтын хувь нийт үйлдвэрлэгдэж байгаа дулааны тоо хэмжээнээс хамаарч байгаа нь ажиглагдаж байна. Иймд тус дулааны станцын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл ЦЭХ-ий зарцуулалтын хэмжээ дулаан үйлдвэрлэлтийн хэмжээнээс үл хамаарсан тогтмол байдалтай байна.

Одоогийн байдлаар Амгалан дулааны станцын дэргэд өөрийн хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хангамжид зориулан баригдсан дэд станцын үндсэн трансформаторын суурилагдсан чадлын ашиглалтын хувь 30 хувь орчим байгаа ба тус дэд станцаас шинээр баригдах өргөтгөлийн БУА-ын явцад хэрэглэх ЦЭХ-ий хэрэглээг хангаад зогсохгүй цаашид дотоод хэрэглээг хангах бүрэн бололцоотой байна.

2.6.2. Усан хангамжийн эх үүсвэр

Усан хангамж: Одоогийн байдлаар АДС нь технологийн усны үндсэн хэсгийг станцын хашаан дотор гаргасан гүний 6 худгаас авч ашигладаг. Ажиллагааны горимын дагуу дулааны оргил ачааллын үед дээрх 6 худгаас гадна, хотын ус сувгийн усаар нөхөж хангадаг байна.



Зураг 4. АДС-ын техникийн ус хангамжийн бүдүүвч схем

Ус ашиглалтын төрөл, хэмжээ: Төсөл хэрэгжүүлэгчийн усны хэрэглээнд цахилгаан, дулааны үйлдвэрлэлд ашиглагдах технологийн ус, тоног төхөөрөмжийн угаалга, цэвэрлэгээнд ашиглагдах техникийн ус, ажиллагсдын унд, ахуйн хэрэглээ, ногоон байгууламжийн усалгаа, тоосжилт дарах усны хэрэглээний ус багтах бөгөөд тус бүрд хэрэглээг тооцон доор үзүүлэв.

Хүснэгт 4. Нийт усны хэрэглээ

№	Усны зориулалт	Өдөр/м ³	Сар /м ³	Жил/м ³
1	Нийт технологийн зориулалтын ус	536.5	16094.7	96568.0
		4560.0	136800.0	1 641 600.0
2	Техникийн усны хэрэглээ	5.0	150.0	1800.0
3	Унд ахуйн хэрэглээ	30.0	900.0	10 800.0
6	Тоосжилт, замын суурь нягтаршуулах	5.0	21.4	128.5
7	Цэвэр усны хэрэглээ	5136.5	153 966.1	1 750 896.5

Технологийн хэрэгцээнд: Тус станц жилдээ 96,568 м³ усыг технологийн усны нөхөн сэлбэлтийн зориулалтаар авч ашигладаг байна. Технологийн хэрэгцээний усыг 500 м³ багтаамжтай 1 ширхэг нөөцийн баканд хуримтлуулан насосоор шахан технологийн хэрэгцээнд нийлүүлдэг. Шинээр баригдах станцын хими, ус цэвэрлэгээний нийт хүчин чадал нь дотоод хэрэгцээний усны алдагдлыг оруулж тооцоход зуны улиралд 193 т/ц, өвлийн улиралд 188 т/ц болж байна.

Техникийн ус: Тоног төхөөрөмжийн угаалга, ариутгалд ашиглах ус бөгөөд өдөрт 5.0м³, сардаа 150м³, жилдээ 1800м³ ус ашигладаг байна.



Унд ахуйн хэрэгцээний ус: Ажилчдын унд ахуйн хэрэглээний усыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 сарын сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаал /Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай/-ын 12 дугаар хавсралт орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны нормд “Төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдсон орон сууцны хэрэглээгээр 200 л/хоног/хүн гэж зааснаар тооцож гаргалаа. Тус станц нь 2 ээлжээр ажиллана гэж тооцвол нэг ээлжинд 150 орчим ажилтан ажиллах бөгөөд өдөрт 30м³, сард 900м³, жилд 10 800м³ ус ахуйн хэрэглээнд ашиглана.

Нөхөн сэргээлтэд шаардагдах ус: Хэдий хэмжээний талбайг услахаас хамаарч шаардагдах усны хэмжээ бодогдоно. Төсөл хэрэгжүүлэгч нь одоогоор төслийн талбай орчмын 2500м² талбайд усалгаа хийнэ гэж тооцлоо. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13-р хавсралтад 1м² талбайг услахад 2л ус шаардлагатай гэж нормчилсон байна. Төслийн талбайд нэг удаагийн усалгаанд 5000л ус хэрэглэдэг, жилийн 4-9 сард 7 хоногт 1 удаа усалгаа хийгдэнэ гэж сард 21.4м³, жилд 128.5м³ ус хэрэглэгддэг байна.

2.6.3. Төмөр зам, автозам

Амгалан дулааны станцын баруун, баруун урд талд Амгалан цогцолбор, Турк-Монголын хамтарсан сургууль, “Очир дагинас” ХХК зэрэг томоохон байгууллагуудын орчинд хатуу хучилттай авто замтай, харин дулааны станц хүртэл 200-300метр сайжруулсан шороон замтай. Станцын хашааны урд талаар сайжруулсан шороон замаар өөрийн тээврээр үнс шаараг тээвэрлэж ДЦС-4 ТӨХК-ний үнсэн санд хаядаг. Амгалан дулааны станцын эзэмшлийн хашаан дотор бетонон хучилттай нэг урсгалтай замтай. Станцын хашааны зүүн урд талаас төмөр замын салаа зам орж вагон хөмрөгчийн барилга хүртэл явах бөгөөд энэ замаар станцын хэрэгцээнд нүүрс тээвэрлэдэг. Энэхүү салаа замаар ирсэн нүүрс тэй вагоныг нүүрсний агуулахад хөмөрч хоосон вагоныг вагон шилжүүлэгчээр буцааж төмөр зам дээр шилжүүлдэг. Энэ зам дээр 8 вагоныг нэг удаа зэрэг байрлуулах боломжтой. Одоо ашиглагдаж байгаа салаа төмөр замаар станцын нүүрс тээврийн зориулалтаас өөр ачаа тээвэрлэлт хийгддэггүй. Энэ төмөр зам нь хотоос зүүн чиглэлд орох гарах авто зам хөндлөн гардаг.

2.7. ХОГ ХАЯГДАЛ

Дулааны цахилгаан станцад цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх явцад завсрын бүтээгдэхүүн гарахгүй, үйлдвэрлэлийн явцад үнс шлак, хаягдал ус, уур, нүүрсний хаягдал, утааны хий, нефтийн бүтээгдэхүүн асгарах зэрэг бодит болон болзошгүй байдлаар гарах хог хаягдал гардаг.

Завсрын бүтээгдэхүүн: ДЦС-аас завсрын бүтээгдэхүүн гарахгүй болно.

Хатуу хаягдал

Ахуйн хог хаягдал / Нэр төрөл, хэмжээ, эх үүсвэр, түүнийг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, цэвэрлэх, зайлуулах, устгах арга хэлбэр/

Эх үүсвэр: ДЦС-д ажиллагсдын ахуйн хог хаягдал, асгарсан шатахуун тосолгооны материалын цэвэрлэгээнээс гарсан алчуур, болон бусад эд зүйлс, элс гэх мэт.



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ “ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэр төрөл: Тус ДЦС нийт 289 хүн ажиллагсадтай бөгөөд ашиглалтын 2 ээлжээр ажиллана. Иймд ахуйн хуурай хог хаягдал гардаг. Мөн шатахуун болон бусад бодис тос санамсаргүй асгарсан тохиолдолд цэвэрлэгээнээс гарсан шатахуунтай алчуур, элс зэрэг гарах магадлалтай.

- ✓ Ахуйн хэрэглээнээс гарсан цаас, сав, баглаа, боодол, амны цаас, гялгар уут, бичгийн хэрэгслийн цаас, амны алчуур, хүнсний бүтээгдэхүүний цаасан сав баглаа боодол, хоол хүнс бэлтгэх явцад гарсан хаягдал
- ✓ Асгарсан шатахуун тосолгооны материалыг шингээж авсан цаас, алчуур, элс шороо
- ✓ Хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан эд, гутал хувцасны уранхай, тасархай гэх мэт хог жилдээ.

Хэмжээ: Ахуйн хэрэглээнээс үүдэлтэй хог хаягдал нь сард дунджаар 2.5 тн хэмжээтэй үүсдэг.

Цуглуулах, зайлуулах: /Хатуу хогийн цэг/ Ахуйн хэрэглээнээс гарч байгаа хатуу хог хаягдлыг тусгай зориулалтын хог хаях цэгт хаяна. Хог хаягдлыг тухайн объект тус бүр дээр ялгалт хийж хаядаг. Эдгээр хог хаягдлуудыг Улаанбаатар хотын тусгайлан бэлтгэсэн Улаанчулуутын хогийн цэгт машинаар зөөвөрлөн аваачин хаядаг.

Үнс шаарганы хог хаягдал

Амгалан дулааны станцаас одоогийн байдлаар өдөрт дунджаар 193.3тн, жилд 21 411.0тн үнс шаарга үүсч байгаа бөгөөд цаашид өдөрт 266.65тн/өдөр, 97 332.7тн болж нэмэгдэнэ. Станц нь үнсийг хуурайгаар зайлуулдаг бөгөөд “ДЦС-4” ТӨХК-ний үнсэн сан руу автомашинаар зайлуулж байна.

Улаанбаатар хотод барилга болон замын бүтээн байгуулалтын ажил ихээхэн явагдаж байгаа бөгөөд үүнд дэгдэмхий үнсийг ашиглуулах, хэрэгцээт түүхий эд болгох чиглэлд идэвхитэй ажиллахад станцын орлогыг нэмэгдүүлэх нэг нөхцөл болно.

Шингэн хаягдал

“Амгалан дулааны станц” ТӨХК-аас технологийн шингэн хаягдал үүсэхгүй бөгөөд зөвхөн ахуйн бохир ус үүсч, төвлөрсөн ариутгах татуургын системд нийлүүлдэг байна. Энэ хаягдал нь өдөрт 21м³, сард 630м³, жилд 7560м³ хэмжээтэй үүснэ.

Эмнэлгийн аюултай хог хаягдал

“Амгалан дулааны станц” ТӨХК-ний эмнэлгээс гарч байгаа аюултай хог хаягдлыг “Элемент” ХХК-тай гэрээ байгуулан устгуулах, халдваргүйжүүлэх, тээвэрлүүлэх үйлчилгээг 7 хоногт 2 удаа татан авалт хийлгүүлэхээр хамтран ажиллаж байна.

Хийн хаягдал

“Амгалан дулааны станц” ТӨХК-иас гарч байгаа хийн байдалтай хаягдал нь станцын утааны яндангаар хаягдаж байгаа утааны хий, уг хийнд агуулагдаж байгаа хорт бодисын хаягдал бөгөөд энэ талаар болзошгүй болон гол нөлөөллийн тухай бүлгүүдэд тодорхой авч үзсэн болно.

Цацраг идэвхит бодисын хаягдал

Станц цацраг идэвхит бодис хэрэглэдэггүй боловч Шивээ-Овоо болон Багануурын



уурхайн нүүрс түлдэг учраас үнсэнд цацраг идэвхит элементийн илэрц байдаг.

Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг дахин ашиглах боломж

Үнсэн сангийн үнсийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж

Манайд үнсийг цаашид хоёрдогч бүтээгдэхүүн болгон ашиглахад хамгийн хүндрэл учруулж буй асуудал нь нүүрсэнд агуулагдах цацраг идэвхит бодис үнсэнд хэвээрээ хадгалагдсаар байна. Иймээс цацраг идэвхийн хэмжээ нь хүний эрүүл мэндэд стандартаар зөвшөөрөгдсөн хэмжээнд байгаа эсэхийг тогтоох явдал чухал юм. Үнсний байгалийн цацраг идэвхийн хэмжээ нь түүнд агуулагдах уран, тори тэдгээрийн байгалийн цацраг идэвхит задралын бүтээгдэхүүнд мөн кали 40-ийн агуулалтаар тодорхойлогдоно.

Үнсийг дахин ашиглах дараах боломж, шаардлагууд байдаг байна. Үүнд:

- ✓ Үнсэнд агуулагдах түлшний хэмжээ 20-30% байхал керамзит, нүхтэй бетон, силикатан тоосго хийх боломжгүй. Гэхдээ ийм үнс нь цемент, аглопорит, шавар тоосгоны үйлдвэрт түүхий эдийн хольц болгон ашиглаж болох ба мөн ХАА-д хөрсийг хүчиллэг болгоход ашигладаг. Цементийн үйлдвэрт кальцийн исэл ихтэй үнсийг ашигладаг. Шаварны оронд үнсийг ашигласнаар карбонатын нэгдлийн хэмжээг, мөн усны хэрэгцээг багасгана. Портланд цементэнд ашиглах үнс нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Зуурмаг хийснээс 7 хоногийн дотор царцах, барьцалдсаны дараа 3 хоногийн турш чийглэгээ барих цахиурын хоёрч исэл 40%-иас багагүй, цахиурын гуравч исэл 2%-иас ихгүй, шатамхай үлдэгдэл 2%-иас ихгүй, чөлөөт кальцийн исэл 10%. Үнс оролцсон портланд цемент бат бөх, эхний үед хатах хурд нь бага, сульфатанд тэсвэрлэх чадвар их, дулаан дамжуулалт бага, өөрчлөлтөнд бага ордог, хүйтэнд тэсвэртэй байдаг байна.
- ✓ Үнс шааргын ихэнхи хэсэг нь нүүрсэнд агуулагдах органик бус хэсэг болох шавар, кварц зэргийн шаталтын бүтээгдэхүүн юм. Иймд, цахилгаан станцаас хаягдах үнсний хэмжээ нь ашиглаж буй нүүрсний шинж чанараас хамааран ялгаатай байх нь ойлгомжтой бөгөөд дунджаар органик бус хэсэг нь 15% орчим байдаг. Лабораторийн шинжилгээ, туршилт сорилын дүнгээс үзэхэд үнсэн сангийн үнснээс жилдээ ойролцоогоор 13000-15000тн кальцийн исэл гаргаж авах боломжтой бөгөөд цаашид судалгаа хийх нь зүйтэй.

Хатуу хог хаягдлыг дахин ашиглах

Шил, металл, хуванцар, материал цаас зэрэг хоёрдогч түүхий эд болгон ашиглах боломжтой материалууд хог хаягдалд их хэмжээгээр агуулагдаж байдаг. Эдгээр материалуудыг хогноос ялгаж ашиглан дахин боловсруулалт хийж ашиглах нь байгалийн баялгийн нөхөн сэргээгдэхгүй нөөцийг хэмнэхээс гадна боловсруулан дарж устгах нийт хогны хэмжээг багасгах ач холбогдолтой. Хогны ангилан төрөлжүүлсний дараа дахин ашиглах боломж нь материал тус бүр дээр өөр өөр байна. Хогны дахин ашиглаж болох хэсгийн эзлэх хувь нь улс орны эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлөөс хамаарч янз бүр байна.

Хүснэгт 5. Ахуйн хог хаягдлыг дахин ашиглах боломж

Материалын төрөл	Дахин ашиглах боломж (%)
Хөнгөнцагаан лааз	80-95
Металл лааз	70-85
Хуванцар материал	30-70
Шил	50-80



Цаас	40-60
Цаасан хавтанцар	25-40

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Станцын ашиглах тоног төхөөрөмжийн хүчин чадал их байх ба тухайн орон нутгийн байгаль-экоосистемийн бүрэлдэхүүн хэсэг болон агаар орчин, усны нөөцөд шууд нөлөөлж, эдгээр нь урт хугацааны турш хүчтэй нөлөөлөлд хамрагдаж, ихэнхдээ буцалтгүй шинжтэй байна. Цахилгаан дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааны улмаас агаар орчныг бохирдуулагч хорт хий, тоос тоосонцор, дуу чимээ, усны уур үүсэх, үндсэн эх үүсвэр болох ус, нүүрсний нөөцөд үзүүлэх нөлөөлөл, улмаар хөрс ургамал, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг энд дурьдаж болох юм.

3.1. УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ

Өнөөгийн төлөв байдал: Эх газрын эрс тэс уур амьсгалаас шалтгаалан өвөл харьцангуй хүйтэн, 1-р сарын дундаж агаарын температур $-27,4^{\circ}\text{C}$, хамгийн дулаан нь 7-р сард, агаарын дундаж температур $17,1^{\circ}\text{C}$ байдаг. Хамгийн их температур 7-р сард 32°C , 1-р сард -10°C байдаг бөгөөд үнэмлэхүй хамгийн их температур нь 7-р сард 39°C , 1 сард 4°C хүрч байжээ. Хоногийн дундаж агаарын температур -25°C -аас хүйтэн өдрийн тоо жилд дундажаар 56 хоног, $+15^{\circ}\text{C}$ –аас дулаан өдрийн тоо 55 хоног байдаг. Хүйтрэлгүй үе нь хоногийн дундаж агаарын температур 0°C -ын заагаас давж дулаарахаас өмнө заагийг давж хүйтрэх хүртэл 180 хоног үргэлжилдэг байна.

Уур амьсгалын хүчин зүйлс: Төслийн талбай орчимд жилийн турш цэлмэг өдрийн тоо их боловч эрчим хүчний хэрэглээ ихэсдэг хүйтний улиралд агаарын бохирдлын хэмжээ нэмэгдэж энэ нь буцаад нарнаас ирэх цацрагийн хэмжээг бууруулан эрчим хүчний хэрэгцээг улам бүр ихэсгэнэ.

- ✓ Төслийн бүс нутагт сүүлийн жилүүдэд агаарын дундаж температур болон жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ аль аль нь алгуур нэмэгдэж байгаа хэдий ч түүнд эрчимшил ихтэй аадар тунадасны эзлэх хувь ихтэй байна. Хэт халуун болон хэт хүйтэн өдрийн тоо өсч уур амьсгал эрс тэс болох байдал ажиглагдаж байна. Энэ нь ДЦС-ийн үйлдвэрлэлийн ачааллыг нэмэгдүүлэх, хэвийн үйл ажиллагааны горимыг тодорхой хэмжээгээр алдагдуулахын зэрэгцээ үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник хэрэгслийн ажиллах горимд өөрчлөлт оруулах дам нөлөөтэй юм.
- ✓ Түүнчлэн эрчимшил ихтэй, усархаг аадар тунадасны давтагдал нэмэгдэж уруйн үер болох нөхцөл ихэсч байгаа нь төслийн үйл ажиллагаанд саад болоод зогсохгүй бүтээн байгуулалтыг эвдэн сүйтгэх эрсдэлийг дагуулж байна.
- ✓ Аянга цахилгаантай өдрийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаагийн зэрэгцээ зөвхөн зуны улиралд төдийгүй IV-X саруудын аль ч хугацаанд ажиглагдаж байгаа нь дамжуулах шугам ба дэд станцад маш их аюул учруулах эрсдэл тулгарч байна. Иймд тул аянга зайлуулах, газардуулгын ажлыг байнга шалгах, тоог нэмэгдүүлэх, стандартыг цаг ямагт мөрдөх шаардлага үүсч байна.
- ✓ Жилийн дундаж температур сөрөг утгатайн дээр хэт хүйтэн өдрийн тоо, нойтон цастай болон цастай өдрийн тоо нэмэгдэж байгаа нь цахилгаан дамжуулах шугамыг унагах, цахилгааны тусгаарлалтыг багасгах, үйлдвэрлэлийн ачааллыг ихэсгэхийн зэрэгцээ замын мөстлөг үүсгэж машин механизмын хэвийн ажиллагаанд сөргөөр нөлөөлөн ажлын цагийг алдагдуулах нөхцөлийг бас нэмэгдүүлж байна.



- ✓ Салхитай холбоотой цаг агаарын аюултай үзэгдлүүд болох хүчтэй салхи, шороон болон цасан шуургатай өдрийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа нь температурын эрс өөрчлөлтийг дагуулж цахилгаан дулаан үйлдвэрлэлийн ачааллыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ цахилгаан түгээх шугам сүлжээнд ихээхэн гэмтэл учруулдаг.
- ✓ Цаг агаар, уур амьсгал нь нэг талаас төслийн үйл ажиллагаанд дээрх байдлаар сөргөөр нөлөөлөхөөс гадна нөгөө талаас төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг нэмэгдүүлэх үйлчилгээг бас үзүүлдэг. Тухайлбал Улаанбаатар хотын газарзүйн байрлал нь өөрөө хотын тэлэлтийг хязгаарлах, төвлөрлийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг ихэсгэх шалтгаан болохын дээр уул хөндийн шинжтэй салхи ноёлж хотын төврүү чиглэсэн салхины горимыг бий болгосон нь төслөөс орчинд хаягдах аливаа бохирдуулагч элементүүдийг нэг газраас нөгөө газарт тархаах нэг хүчин зүйл болж байгааг бодит хэмжилт болон HYSPLIT загварын үр дүн харуулж байна.
- ✓ Дулаан цахилгааны үйлдвэрлэлийн түүхий эд нь түүхий нүүрс болон мазут гэх мэт хүлэмжийн хийн үндсэн эх үүсвэр байдаг учир дэлхийн дулааралд томоохон нөлөөг үзүүлдэг. Иймд ДЦС нь эрчим хүчний дотоод хэрэглээгээ багасгах, дамжуулах, түгээх үеийн алдагдлаа бууруулах, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөө шинэчлэх, үр ашгийг дээшлүүлэх, хорт утааны шүүлтүүрийг байнга хянах, сайжруулах зэргийг цаашдын төлөвлөгөө, үйл ажиллагаандаа тусган ажиллах шаардлагатай байна.
- ✓ Төслийн аливаа бүтээн байгуулалт, сэлбэн засварлах үйл ажиллагаандаа улсын тогтвортой, ногоон хөгжлийн бодлогын үзэл санааг шингээж, барилгын норм ба дүрмийг чанад мөрдөж материалын болон гүйцэтгэлийн чанарт анхаарч ажиллавал цаг агаарын аюултай, гамшигт үзэгдлээс учирч болох эрсдэл, хохирол тодорхой хувиар буурах боломжтой юм.

3.2. АГААРЫН ЧАНАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Өнөөгийн төлөв байдал: Төслийн талбай нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт байрлана. Энэ орчмын агаарын чанарт нөлөөлж байгаа гол нөлөөлөл нь гэр хорооллын түүхий нүүрсний шаталтаас үүсэх утаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс гарах хорт утаа болно. Иймд бид Улаанбаатар хотын агаарын бохирдлын ерөнхий байдлыг авч үзлээ.

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчимд агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), том ширхэглэгт тоосонцор (PM_{10}), нарийн ширхэглэгт тоосонцор ($PM_{2.5}$), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат болон автомат бус багажаар хэмжин тодорхойлж байна.

2018 оны 12 дугаар сард хэмжигдсэн агаар бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг 2017 оны 12 дугаар сартай харьцуулахад PM_{10} тоосонцрын дундаж агууламж 37мкг/м^3 -ээр буюу 22%-аар, $PM_{2.5}$ тоосонцрын дундаж агууламж 27мкг/м^3 -ээр буюу 23%-аар, азотын давхар исэл NO_2 -ийн дундаж агууламж 13мкг/м^3 -ээр буюу 26%-аар тус тус их байсан бол хүхэрлэг хий SO_2 -н дундаж агууламж 11мкг/м^3 -ээр буюу 17%-аар бага байсан байна.

3.3. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ, ГЕОМОРФОЛОГИ



Геологийн тогтоц

Геологийн тогтоцын хувьд Улаанбаатар хотын район Монгол орны геологи тектоникийн ангиллын Хэнтийн геосинклиналь хотгорт харъяалагдана. Районы геологийн тогтцод доод карбон, доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдас чулуулаг, доод мезозойн интрузив бүрдэл оролцоно.

Судалгаанд хамрагдаж байгаа объект нь Улиастай голын баруун жигүүрт байрлах ба гидрогеологи-инженер геологийн нөхцөлийн хувьд дөрөвдөгчийн сэвсгэр хурдас бүхий голын II дэнжид байрлах бөгөөд урьд өмнө судалгааны ажлын хүрээнд өрөмдсөн гидрогеологи-инженер геологийн хайгуулын цооногуудын геологи-литологийн зүсэлтээс үзэхэд элсэн чигжээстэй бул чулуутай сайр хайрга бүхий хөрс чулуулаг нь (голын адаг орчимд) 35-42м зузаантай, элсэн чигжээстэй бул чулуутай сайр сайрган (голын дунд хэсэгт) хөрс чулуулаг нь 5-10м зузаантай, шавар чигжээстэй сайр сайрган хөрс нь (голын дунд хэсэгт) 15-20м зузаантай, харин үндсэн чулуу болох хувирмал чулуулаг (занар, гуранз) нь голын эхэн хэсэгт 20м-ээс, голын адаг хэсэгт 25-38м-ээс эхлэн доош үргэлжилнэ. Харин голын адаг орчимд үндсэн чулуулаг нь нилээд доороос (50-60м-ээс) ордог байна.

“Амгалан дулааны станц” ХХК орших газар нутагт геоморфологи, гидрогеологийн тухайлсан судалгаа хийгдээгүй бөгөөд харин Улаанбаатарын дүүргүүдийн нийтэд нь хамруулж хийсэн судалгааны ажлын үр дүнг энд голчлон оруулсан болно.

▲ *Доод карбоны чулуулаг (C₁)*

Районд тархах чулуулгийн дотроос хамгийн эртнийх нь болох доод карбоны чулуулгууд Богд уулын хойт хажуу, Туул голын хойт хэсгийн уулсын геологийн тогтцыг бүрдүүлж өгнө. Энэ насны чулуулгуудад алевролит, элсэн чулуу, конгломерат, гравелит, яшма маягийн цахиурлаг чулуулгууд зонхилон оролцоно.

▲ *Доод цэрдийн чулуулаг (K₁)*

Доод цэрдийн настай чулуулаг Туул голын грабенийг дүүргэн тогтсон нь анхны геологийн судалгаанаас мэдэгдэж байсан бөгөөд газрын гадарга дээр Толгойт, Мааньтын овооны хавиар ил гарч иржээ. Литологийн найрлагаар нь дээд ба доод гэсэн 2 горизонт болгон ангилагджээ.

Доод горизонтын зүсэлтэнд конгломерат зонхилон орж уг горизонтын онцлогийг тодорхойлдог бол дээд горизонтын зүсэлтэнд конгломерат, элсэн чулууны үеүдийн завсар 0.2-2.0 м хүртэл зузаантай шаврын үеүд байрлаж нийт зүсэлтийн төрхийг өвөрмөц онцлогтой болгоно.

Доод цэрдийн чулуулгууд дороо орших доод карбоны чулуулгуудын угаагдлын гадарга дээр өнцгийн эрс үл нийцлэгээр бараг өргөргийн дагуу чиглэлтэй суналыг үүсгэж 15-20° орчим өнцгөөр шахаж байрлана. Доод цэрдийн чулуулгийн зузааныг өрөмдлөг ба геофизикийн судалгаагаар 200м орчим болохыг тодорхойлжээ.

▲ *Неогены хурдас (N)*

Неогены хурдас Туул голын грабены хэмжээнд доод цэрдийн чулуулгийн дээр байрлаж тархах бөгөөд газрын гадарга дээр Тасган овоо, Наран, Мааньтын овоо, Толгойт, Улаан хуаран, Шар хад зэрэг газраар ил гарч ирсэн байна.

▲ *Дөрөвдөгчийн галавын хурдас*

1986 оны “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн 1:10000 масштабтай инженер



геологийн зургийн тайлбар бичиг”-т тус районд тархсан сэвсгэр хурдасны гарал үүслийн ангилал хийж дөрөвдөгчийн хурдсыг ялгасан байна. Үүнд: нийт гарал үүслийн үндсэн 6, холимог 5 төрлийг ялгасан ба насны 4 хязгаарыг тогтоосон байна.

Дунд-дээд дөрөвдөгчийн настай хурдаст Туул голын хөндийн аллювийн хурдасны доод хэсэг, томоохон голуудын аллюви-пролювийн хурдас, Хүрхрээгийн амны флювиогляциал-мөстлөгийн хурдсыг тус тус ялган хамааруулсан болно.

Туул голын хөндийг дүүргэх хурдасны дээд хэсэг, уулын бэл хормойн делювий болон делюви-пролювийн хурдас, уулын жижиг амуудын аллюви-пролювийн хурдсуудыг дээд дөрөвдөгч-голоцонд хамааруулан ангилсан байна. Туул голын нам өндөр татмын аллювий, хуурай сайр, том жалгуудын хошуурсан туугдсын пролювий болон техноген хурдсыг голоцонд оруулж, уулын хажуу, оройн хэсгийн элювиал-делювиал хурдсын насны ангиллыг хийгээгүй байжээ.

1. *Элюви-делювийн хурдасны геологи гарал үүслийн комплекс (eαQ)*

Ангилалдаагүй дөрөвдөгчийн настай элюви-делювийн хурдас нь дунд ба нам өндөрлөг уулсын хажуу хэсэгт доод карбоны кристалл фундаментийг хучиж өргөн тархана. Усан хагалбарын хажуугийн дээд хэсэг болон доод карбоны чулуулаг гадаргад ойр орших хажуугийн дунд-доод хэсгийн налуу багатай гадаргууд газрын гадаргад шууд илрэх ба хажуугийн бусад хэсгүүдэд делювий, делюви-пролювийн хурдас харилцан адилгүй зузаантай хучсан байдаг.

Элюви-делювийн хурдасны зузаан янз бүр, Баянхошуу ба Маахуур толгойн районд 0.5-6.0 м, Буянт-ухаагийн районд 1.0-15.0 м хүртэл зузаантай оршино. Хурдасны бүрэлдэхүүнд элс, шаварлаг материалаар чигжигдсэн хайрган хөрс өгөршлийн бүсэд хэмхдэс материалыг агуулсан шавранцар, шавар тохиолдоно.

2. *Делюви-пролювийн хурдасны геологи-гарал үүслийн комплекс (αPQ_{III-IV})*

Дээд дөрөвдөгч орчин үеийн настай делюви-пролювийн хурдас усан хагалбарын хажуугийн доод хэсэг, налуу багатай өргөн уужим бэл хормойд өргөн тархана. Тухайлбал: Нисэх, Яармаг болон судалгааны талбайн баруун хойт хэсгийн Туул голын хөндийд тулж ирсэн уулын жижиг амуудын адгийг хамрах бөгөөд хөрсний ба байгалийн бусад нөхцлөөрөө барилга байгууламж барихад хамгийн тохиромжтой талбай юм. Уг комплексийн хурдсын бүрэлдэхүүнд шавранцар ба элсэнцрээр чигжигдсэн том хэмхдэс, шавранцар, хайргархаг элсэнцэр зонхилно.

3. *Техноген хурдас (zQ_{IV})*

Улаанбаатарын районд хүн ам суурьшин төвлөрч хот суурин байгуулагдаж эхэлснээр асгамал хөрс үүсч эхэлсэн байна. Тухайлбал: Сэлбийн хөндийн адгийн хотын төвийн орчин, 12, 15, 3, 4-р хороолол, Туул голын хөндийн үйлдвэр, орон сууцны хороолол төвлөрсөн хэсгийг дурьдаж болно. Асгамал хөрс нь уулын хажуугийн идэгдлийн сүлжээг дарж босоо төлөвлөлт хийн барилга байгууламж барих Дэнжийн мөрөгцөгийг тэгшилж засах, Далан шуудуу, зам барих, голын хуучин гольдролыг дарж тэгшлэх, барилга байгууламжийн суурь, инженерийн шугам сүлжээний нүх ухаж гаргасан шороог тэгшилж тараах, мод зүлэг тарих зэрэг ажлын явцад үүсч бүрэлдэж байна.

Асгамал хөрсний зузаан голын хөндийд 0.2-2 м, зарим хэсэгт 4 м, босоо төлөвлөлт хийгдсэн уулын хажуу, бэлд 1-6 м, дарж тэгшилсэн гуу жалгын адагт 10 м түүнээс



их, хотын хог хаях цэгүүдэд 5-15 м хүрнэ. Асгамал хөрс нь ахуйн болон барилгын хог хаягдал бүхий төрөл бүрийн хөрснөөс бүрдэх бөгөөд хучиж тархсан суурь хөрснийхөө үндсэн шинж, бүрэлдэхүүнийг хадгалан харилцан адилгүй нягтарсан байдаг. Орон сууцны барилгууд хорооллын журмаар баригдаж байгаатай уялдан тухайн талбайн гадаргуу 0.2-1.5 м хүртэл зузаантай асгамал хөрсөөр жигд хучигдаж байна. Асгамал хөрсний бүтэц, бүрэлдэхүүн, шинж чанар орон зайн хувьд эрс хувьсдаг.

Голын хөндийд барилга байгууламж орон сууцны хороолол барих үед (ялангуяа Сэлбэ, Улиастай, Толгойт голын хөндийн хойт захын хэсэг, хучин гольдролын орчимд) асгамал хөрсний зузааныг төлөвлөгөөтэйгээр үүсгэн бий болгож ашиглах нь тухайн талбайг голын идэгдлийн суурийн түвшнээс дээшлүүлэх тул төрөл бүрийн физик-геологийн үйл явц, үзэгдэл үүсгэх, газрын гадаргад ус тогтох, намагжих зэрэг явдлаас чөлөөлөх сайн талтай юм.

3.4. ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС

3.4.1. Гадаргын усны сүлжээ, онцлог

Туул гол усны горимын хэв шинжээрээ хаврын шар усны болон зуны хур боррны үерийн горимтой голд хамаарна. Голын урсацыг бүрдүүлэгч үндсэн хүчин зүйл нь зун намрын хур бороо учраас усны түвшин дулааны улиралд ихээхэн тогтворгүй байдаг. 4 дүгээр сарын сүүлч 5 дугаар сарын эхээр хаврын шар усны үер ажиглагдах боловч үргэлжлэх, урсацын хэмжээгээр хур борооныхоос бага байна.

Хаврын шар усны үерийн дараа богино хугацаатайгаар зуны гачиг үе ажиглагдах ба 7 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл зун намрын хур борооны үер ажиглагдаж, гол элбэг устай байна. Хур борооны үерийн их түвшин шар усны үерийнхээс даруй 1,5-2 дахин их байна.

Хур борооны үер дууссаны дараа мөсний үзэгдэл эхлэх хүртэл усны түвшин аажим буурч өвлийн гачиг үе үргэлжилнэ. Голын мөсний үзэгдэл 10 дугаар сарын сүүлчийн арав хоногт эхэлж 11 дүгээр сарын 2 дугаар арав хоногт гол бүрэн хадгалж, 4 дүгээр сарын сүүлч хүртэл дунджаар 149 хоног мөсөн бүрхүүлтэй байна.

Туул голын усны нөөц, горимын өөрчлөлт

Урсацын олон жилийн хэлбэлзлээс үзэхэд Туул голд 1945-1957 онд татруу, 1958-1975 онд элбэг, 1976-1981 онд татруу, 1982-1996 онд элбэг устай үш зонхилж, үүнээс хойш ерөнхийдөө ус багатай үе үргэлжилж байна. Голын олон жилийн дундаж урсац аж ахуйн үйл ажиллагааны түвшин харьцангуй бага байсан 1945-1975 онд 25,61 шоо м/с байсан бол 1976-1989 онд 25,04 шоо м/с, үүнээс хойших урсац элбэгтэй үед нэмэгдсэн байна. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хот орчимд Туул голд усны улирлын чанартай хомсдол байнга ажиглагдаж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд 4 дүгээр сарын сүүлээр Туул голын усны түвшин багасаж, Улаанбаатар хотын усан хангамжийн эх үүсвэрийн орчимд ба түүнээс дооших хэсэгт гол тасрах үзэгдэл ажиглагдаж байна. Үүний гол шалтгаан нь уур амьсгалын өөрчлөлт ба хүний үйл ажиллагааны хам нөлөөлөл юм. Тухайлбал:

Сүүлийн 60 шахам жилд эл сав газрын агаарын дундаж температур 2,0 градусаар дулаарч, хуртунадасны хэмжээ төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Түүнчлэн Улаанбаатар хот орчимд сүүлийн 60 жилд голын урсацын дийлэнх хувийг бүрдүүлдэг 7, 8 дугаар сарын тунадас өсөх, харин 4-6 дугаар сарынх буурах хандлагатай байна. Үүнээс үзэхэд уур амьсгалын өөрчлөлт энэхүү сав газрын хуурайших процесст нөлөө үзүүлж буй боловч усны горимын өөрчлөлтөд шийдвэрлэх нөлөөг энэ сав газар дахь аж ахуйн бүхий л үйл ажиллагаа үзүүлж байна.



**“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ “ АМГАЛАН
ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хур борооны нэг үерийн үргэлжлэх хугацаа 1940-ббд онд 15 хоног байсан бол одоо 12 хоног болж , сүүлийн 60 орчим жилд 2-3 хоногоор богиносгож байна. Энэ нь гол ус багатай байх үеийн үргэлжлэх хугацаа уртсаж, голын сав газарт унасан хур тунадас богино хугацаанд эрчимтэй урсац үүсгэж байгааг харуулж байга.

Хавар агаарын температур аажуу нэмэгдэх явцтай болж буй хийгээд талхлагдсан бэлчээр, сийрэгжсэн ойд тогтох цасны хэмжээ багассанаас голлон шалтгаалж хаврын шар усны үерийн үргэлжлэх хугацаа 14 хоногоор сунжирч байна.

Уур амьсгалын дулаарал, хүний хүчин зүйлсийн зарим нөлөөн дор нөлөөн мөсний үзэгдлийн ажиглагдах ба үргэлжлэх хугацаа, мөсөн бүрхүүлийн зузаанд өөрчлөлт орлоо. Тухайлбал мөсний зузааны хамгийн их хэмжээ 1944-2007 оны хугацаанд Туул –Улаанбаатар харуулд 46 см-ээр нимгэрсэн болно. Мөсний зузааны хамгийн их хэмжээ 12 сарын хоёр дугаар арав хоногт ажиглагдах болж улмаар 30-40 орчим ханогоор эрт ажиглагдах болов. Мөн дээрх хугацаанд мөсөн бүрхүүлтэй үеийн үргэлжлэх хугацаа 16 хоног, мөсний үзэгдэлтэй байх үеийн хугацаа 10 хоногоор тус тус богиноссон байна. Туул голын гадаргын урсацын алдагдал буюу газрын доорх урсацын тэжээх хэмжээ Улаанбаатар хотын усан хангамжийн худгуудын орчимд нэмэгдэж, урсацын алдагдлын бү голын дагуу Тэрэлж, Туулын бэлчир хүртэл өгсөх хандлагатай, улирлын хөдлөлзүйтэй болж байна.

Улиастай гол:

Судалгааны талбайн зүүн хэсэгт Туул голын цутгал гол болох Улиастайн гол орших бөгөөд хойноосоо урагш чиглэн урсаж Амгалан орчмоор Туул голд нийлнэ. Улиастайн гол нь Сэдбэ гол шиг нарийн судлагдаагүй ч урьд өмнө хийгдсэн судалгаагаар зөвхөн Улиастай голын усны химийн найрлагыг тодорхойлох үүднээс дээжлэлт хийгдсэн байна.

Усны сүлжээний гол объект болох Улиастай голын үндсэн тэжээл нь хур бороо болохоор голын усны түвшин ихээхэн тогтворгүй 4-р сарын сүүлч, 5-р сарын эхээр хаврын шар усны үер ажиглагдах боловч хэмжээний хувьд бага, цөөхөн хоног үргэлжилнэ. Хаврын шар усны үерийн дараа нэг хэсэгтээ урсацын гачиг үе болж байгаад 7-р сараас 9-р сар хүртэл зун, намрын хур борооны үер болж түвшин нь эрс дээшилж зарцуулга нь харьцангуй ихсэнэ. 9-р сарын сүүлчээс усны түвшин алгуур бууж заримдаа урсацгүй болж өвлийн гачиг үе рүү шилжинэ.

Улиастайн гол нь бусад голуудын нэгэн адил хур тунадасны усаар тэжээгдэх бөгөөд өвөл урсгалгүй урсгал нь тогтворгүй ба хаврын шар усны болон зуны хур борооны үеэр урсац нэмэгдэнэ. Улиастай голын ус нь газрын доорх устайгаа гидривлик холбоотой оршино. Газрын доорх усны тэжээлийн гачиг үе болох газрын доорх усаа голын ус тэжээж, харин газрын доорх усны тэжээлийн оргил үед газрын доор ус нь голоо тэжээх ба мөн хур тунадасны усаар тэжээгдэж улмаар голын усны түвшин дээшилдэг.

Улиастай голын эргийг дагасан эргийн баруун, зүүн хэсгээр олон тооны булгууд гарсан байдаг бөгөөд эдгээр булгууд нь ундарга харилцан адилгүй, зарим жилд хур бороо ихтэй эил урсацтай байдаг. Сүүлийн жилүүдэд дулааралтаас үүдээд үарим булаг нь урсацгүй болсон байна. Эдгээр ус нь хүн, малын ундны эх үүсвэр болдог бөгөөд ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож, тохижуулаагүй зэргээс болоод эрүүл ахуйн хэрэгцээнд ашиглахад тэр бүр тохиромжгүй юм. Улиастайн гол нь 1960-1970-аад онуудад урсац ихтэй, хүн малын ундаа болж байсан гэж тэмдэглэгдсэн байдаг. Сүүлийн үеийн цаг уурын өөрчлөлтөөс болж Улиастайн гол нь олон хоногоор үргэлжлэн орсон борооны улмаас үерлэж, голын усны түвшин нь эрс нэмэгдэж , олон жилийн дундажаас даруй 1,5-2 м дээшилж байсан. Сүүлийн 5-10 жилийн хугацаанд Улиастайн голийн урсац багасч , зарим жилүүдэд урсацгүй болдог байсан нь уур амьсгалын өөрчлөлт, дулааралтын хугацаатай холбоотой ч зарим тохиолдолд нийгэм эдийн засгийн байдлаа дагаад зах зээлийн харилцаанд шилжсэнээр Улиастайн голын хөндийн дагуу байрласаг суурьшмал хандлагатай





болсон иргэд хашаандаа болон ногооны талбайд ногоо тарьж түүнийгээ Улиастайн голоос услах явдал ихэссэнтэйгээр голын урсац багасхад нөлөөлж байна.

3.4.2. Газрын доорх ус

Гидрогеологийн нөхцөл

Судалгаанд хамрагдаж байгаа объект нь Улаанбаатар хотын зүүн хэсэгт, Туул голын цутгал гол Улиастайн голын 2-р дэнж, Туул голын хөндийн өргөгдсөн 3-р дэнжийн гадаргад байрлах бөгөөд геологийн тогтоц, гидрогеологийн энэ нөхцөлөөсөө шалтгаалан давхарга зүйн ангиллын хувьд 3 давхрага болгон ангилж байна. Үүнд:

- Орчин үеийн дөрөвдөгчийн аллювийн (aIQ_4) хурдасны уст үе.
- Орчин үе-дээд дөрөвдөгчийн аллювийн (aIQ_{3-4}) хурдасны уст үе.
- Дунд-дээд дөрөвдөгчийн аллювийн (aIQ_{2-3}) хурдасны уст үе гэж ангилж болно.

Орчин үеийн дөрөвдөгчийн аллювийн хурдасны (aIQ_4) уст үе нь

Судалгаанд хамрагдаж байгаа объектоос урагш байрлах Туул голын хөндийд тархах бөгөөд ус агуулагч чулуулаг нь бул чулуу, хайр, хайрга, элсээс тогтох бөгөөд хөндийн өргөжсөн хэсэгт уст үеийн зузаан 80-90м хүрдэг. Дээд хэсэгтээ (25м хүртэл) шүүрэлт ус элбэгтэй, уст үе нь дунджаар 1.5м гүнээс илэрдэг, уст үеийн дээд хэсэгт 7.12м, заримдаа 25м зузаантай үе ус нэвтрүүлэх чадвар ихтэй учир энэ үеийг илрүүлсэн цооногийн ундрага 10-40л/с хүрдэг. Ус агуулах чулуулгийн шүүрэлтийн итгэлцүүр 200-400м/хоногоос 30м/хоног хүрдэг. Энэ хурдас нь хур тунадасны усаар, Туул голын усны нэвчилтээр, түүнчлэн алсын урсацаар тус тус тэжээгдэнэ. Хавар, зуны улиралд газрын доорхи усны түвшин дээшлэхэд тэжээгдэл эрс нэмэгддэг. Усны түвшингийн хамгийн өндөр хэмжээ нь гол үерлэж, татмын ихэнхи талбайг эзэлдэг ба 7, 8-р саруудад ажиглагддаг, харин өвөл гол хөлдөхөд тэжээгдэл багасах боловч газрын доорхи усны урсац үргэлжлэн явагддаг. Энэ уст үе давхаргын химийн найрлага нь гидрокорбанот-натри-кальцийн төрөлд хамаарах ба эрдэсжилт нь 0.05-0.2 г/л, хатуулаг маш багатай байдаг. Энэ уст үеийг түшиглэн Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэр болгон ашиглаж байна. Гэхдээ энэ уст үе давхрага нь шүүрэлтийн итгэлцүүр өндөр учир бохирдолтонд амархан өртөж, ихээхэн талбайг хамрах эрсдэл өндөртэй байдаг. Энэ уст давхаргын шүүрэлтийн итгэлцүүр нь 30-50м/хон.

Орчин үе-дээд дөрөвдөгчийн аллювийн (Q_{3-4}) уст үе нь Улиастайн голын хөндийд судалгааны объектыг хамран орших бөгөөд ул хөрсний ус голлон (даралтгүй ус) тархах ба Улиастайн голын хөндийн аллювийн сэвсгэр хурдасны дотор агуулагдаж байгаа ул хөрсний ус нь 1.8-4.0м гүнд оршиж, уст үеийн зузаан нь 8-20м, заримдаа 70м-т хүрдэг. Ус агуулагч чулуулаг нь хайр, хайрга, элс, сайр, сайрга байх бөгөөд энэ уст давхрагын шүүрэлтийн итгэлцүүр нь 30-50м/хон. Урьд өмнө өрөмдсөн цооногийн мэдээллийн баазаас харахад дээрх уст үе бүхий давхрагаас 1.5-2м-ийн түвшний бууралтанд 0.5-1.5л/с ундрагатай байсан байна. Энэ уст үе давхрагын нөөц баялаг нь агаарын хур тунадасны чөлөөт нэвчилтээр, мөн Улиастайн голын хажуугийн шүүрэлт, бас газрын доорхи усны алсын урсацаар голлон тэжээгдэнэ. Ус нь цэнгэг зөөлөн, химийн найрлагаараа гидрокарбонат-натри-кальцийн төрөлд хамаардаг. Гэвч энэ уст үе давхрага бүхий Улиастайн голын баруун, зүүн жигүүрээр гэр хорооллын айлууд байршдаг учраас хойд, зүүн хойд талаас газрын доорхи усны чиглэлээр айлуудын бохирын нүхээр (бие



засах газрын) хөрсний бохирдлын улмаас газрын доорхи ус бохирдож найрлаганд нь бохирдолт илрэх шинж чанар ажиглагдсан байна.

Дээд-дунд дөрөвдөгчийн (alQ_{2-3}) аллювийн хурдасны уст үе нь голчлон Туул голын татам дээрх II, III дэнжид тархсан ба ус агуулах хурдас нь элс, хайр, хайрга, элсэнцэр, шавранцараас бүрдэнэ. Ус агуулах чадвар нь жигд бус, цооногийн ундрага 1.6-10.0м доошлолтонд 0.9-24л/с хүртэл ундрага нь хэлбэлздэг. Урьд өмнө хийгдсэн өрөмдлөгийн ажлын мэдээллээс үзэхэд усны чанар найрлагын хувьд гидрокарбонат-кальци-натри, заримдаа кальци-магнийн төрөлд хамаарагдах ба эрдэсжилт нь 0.7г/л, хатуулаг нь 8.4 мг-экв/л байна. / Гидрогеологийн зураг 2.30./

3.5. ХӨРСӨН БҮРХЭВЧ

Төслийн талбай нь Туул голын цутгал Улиастайн голын баруун дэнж дээр оршино. Газрын гадаргын хэлбэр дүрсийн хувьд дундаж өндөртэй уулсын хоорондын тэгш ёроолтой хөндий, “Улиастай”-н голын дэнжийн системийг хамран оршино.

Судалгаанд хамрагдсан 10.7 га талбайд хээршмэл хүрэн болон голын хайрган хучаас дээр тогтворжсон үлдмэл нугархаг болон хээржүү хэв шинжийн цайвар хүрэн хөрс тархсан боловч хүний үйл ажиллагаа болон аж ахуйн үйл ажиллагааны нөлөөнөөс шалтгаалан хөрсөн бүрхэвч бүхэлдээ устан түүний оронд техноген гаралтай хөрс шорооны холимог битүү бүрхэж, тэдгээрт хөл газрын хог ургамал зонхилсон байна. Судалгааны талбайн талбайн хойд хэсгийн талбай орчмын хөрс ихээхэн доройтолд өртөж, хөрс үүсгэгч эх чулуулаг гадарга дээр ил гарсан байна.

“Монгол орны хөрс” /Акад. Д.Доржгатов, 2003/ номноос дээрх газарт тархсан хөрсний үндсэн шинж чанарын талаарх товч тодорхойлолтыг орууллаа. Үүнд:

Үлдмэл нугын хүрэн хөрс: Судалгааны талбай нь “Улиастай”-н голын хаяа татам, голын дэнжийн системийг эзлэн орших бөгөөд зонхилох хөрсний хувьд үлдмэл нугархаг болон хээршмэл хүрэн хөрс голчлон тархана. Энэ хэв шинжийн хөрс үүсэх шалтгаан нь ойр орчмын өндөрлөг газруудаас нэмэгдэл чийг зөөгдөн ирж, хуримтлагдсаны үндсэн дээр харьцангуй чийглэг орчинг үүсгэж нугархаг хөрс үүсдэг бол харьцангуй чийглэг татмын системд тогтворжсон чийгт гарлын хөрс голын татам геологийн хөгжлийн явцад элэгдэл үүсгэн доош суухад хаяа татам үлдэж, дэнж болон хувиран түүн дээрхи хөрс ургамал хуурай нөхцөлд хувиран хээржүү экосистемийн нөхцөл тогтворжих үед хөрс хуурайшин үлдмэл нугархаг хүрэн хөрс үүсдэг. Энэ хөрсний бусдаас ялгарах онцлог нь ялзмагт А давхарга нь дээд хэсгээрээ цайвар мөртлөө түүний доор илүү хар бараан давхарга үүссэн байдаг. Түүнчлэн дээд хэсэгт чийгт гарлын хөрсний үлдмэл шинж болох ялзмагийн бодисын бөөгнөрсөн тод бараан өнгийн толбо болон нимгэн судал үе тогтсон байдаг. Хөрс үүсгэгч эх чулуулаг нь пролюви, эртний аллювийн гаралтай хөнгөн шавранцар, элсэнцэр байх бөгөөд урсгал усны үйл ажиллагааны нөлөөгөөр элсэн болон шавран үе тод ялгаран тогтсон байдаг.

Хөрсний судалгаа гүйцэтгэсэн цогцолбор болон ойр орчмын талбай нь техноген нөлөөлөлд эрчимтэй өртөн, хөрсний үржил шимт үе давхарга зулгаран арилж, хөрс үүсгэгч эх чулуулаг гадарга дээр ил гаран, хөрсөн бүрхэвч анхдагч шинж чанараа бүрэн алдаж, эвдрэлд орсон техноген хөрс үүссэн байна.

Хөрсний элэгдэл эвдрэл

Хөрсний судалгаа хийсэн төслийн талбайн хөрс бүхэлдээ хүчтэй элэгдэлд өртөн



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ “ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хөрс үүсгэгч эх чулуулаг гадарга дээр ил гаран үржил шимт давхарга устан алга болсон байна.

Хөрсний бохирдол

Хөрсний судалгаа гүйцэтгэсэн төслийн талбайн хойд хэсэгт ногоон байгууламж бүхий талбай зэрэг газруудад хөрсөн бүрхэвчтэй, бусад талбайг бетондсон учир хөрсний эвдрэл, бохирдолын төдийлөн нөлөө үзүүлэхгүй байх боломжтой.

Талбай орчмын хүнд элементийн судалгааг хогийн цэг орчмын техноген хөрс болон автозам, зогсоолын орчмын нүцгэн хөрс бүхий газраас дээж цуглуулан өргөн тархалтай хүнд элементүүдийн агууламжийг тодорхойллоо.

Хүснэгт 6. Хөрсний хүнд элементийн бохирдлын үзүүлэлт

№	Дээжний нэр	Агууламж, мг/кг									
		Al	Ca	Mg	K	Fe _{нийт}	As	Ba	Be	Bi	Cd
1	Нүүрсний агуулах	4.16	1.97	0.46	1.74	2.57	12.15	548.1	<5.0	<10.0	<1.0
2	Нүүрсний агуулах орчмын цэвэр хөрс	4.37	2.31	0.45	1.96	2.53	11.08	593.6	<5.0	<10.0	<1.0
3	Хүлцэх агууламж /MNS 5850:2008/						4.0				1.5
Үзүүлэлт		Co	Cr	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb
4	Нүүрсний агуулах	8.89	35.04	19.04	16.91	23.16	605.3	<5.0	16.52	430.9	56.01
5	Нүүрсний агуулах орчмын цэвэр хөрс	9.98	43.28	39.5	19.05	29.34	498.6	<5.0	15.07	581.4	32.63
6	Хүлцэх агууламж /MNS 5850:2008/	40.0	100.0	80.0				3.0	100.0		70.0
Үзүүлэлт		Sb	Se	Sr	Ti	V	Y	Zn	Zr		
7	Нүүрсний агуулах	<10.0	9.48	244.6	2117	40.93	15.72	71.6	37.92		
8	Нүүрсний агуулах орчмын цэвэр хөрс	<10.0	12.6	244.1	2354	47.13	11.46	76.75	39.42		
9	Хүлцэх агууламж /MNS 5850:2008/		8.0	700.0		130.0		150.0			

Талбайгаас цуглуулсан дээжинд хийсэн лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд нийт хөрсөнд хүнцэл, молибден агууламж, нүүрсний агуулах орчмын цэвэр хөрсөнд селений агууламж харьцангуй өндөр гарсан байна. Бусад хүнд металлын агуулгын хувьд бүгд хүлцэх стандарт агууламжаас даруй хэд дахин бага байна.

3.6. УРГАМЛАН НӨМРӨГ

Ургамалжлын төлөв байдал

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 8-р хорооны нутаг дахь төслийн талбай түүний эргэн тойрон дахь ургамал нөмрөгт судалгаа хийж, газрын төлөв байдал, ургамалжлын хэв шинжүүдийг тогтоох бичиглэл хийлээ. Нийт талбайн хэмжээ 10.7 га.

Газрын гадаргуу

Нийт газрын гадаргуу тэгшивтэр хотос

Ургамалжил

Судалгаа явуулсан талбай нь ургамал газарзүйн мужлалаар Евро-Азийн хээрийн их муж, Дагуур Монголын (Төв Азийн) дэд их муж, Дагуур-Монголын уулын ойт хээрийн муж, Орхон-Сэлэнгийн дэд мужид хамаарагдана.(Үндэсний атлас, 1990 он)





Зүйлийн бүрэлдэхүүн: Ургамал бүлгэмдэл флорын баялгаараа ядмаг болсон. Уулын хээрийн Хялгана-алаг өвст бүлгэмдэл нь нэг наст Шарилжит бүлгэмдлээр солигдож антропогенийн сукцесст (хүний нөлөөллийн улмаас) өөрчлөлт орсон.

Ургамалжлын арви: Арвийн үнэлгээний хувьд бүлгэмдлийн ихэнх ургамлууд нь **sp-sol** арвитай байна. Харин зонхилогч зүйл *Artemisia scoparia*-ямаан Шарилж **cop1** арвийн үнэлгээтэй.

Ургамалжлын тусгааг бүрхэц: Бүлгэмдлийн нийт тусгааг бүрхэц нь 5% ба үүнээс 2.5%-ийг ямаан Шарилж бүрдүүлж байна. Энэхүү нэг наст ургамал нь Хялгана-алаг өвст бүлгэмдлийн үндсэн зүйл ургамлуудыг түрж өөрийн тусгааг бүрхэц, арви, өсөлт хөгжилтөөрөө давамгайлан ургаж байна. Дээрх арви, тусгааг бүрхэцийн үнэлгээ өөрчлөгдсөнөөр Хялгана-алаг өвст бүлгэмдэл Шарилжит бүлгэмдлээр солигдож антропогенийн сукцесст орсныг илэрхийлж байна.

Ургамалжлын өсөлт, хөгжилт: Бүлгэмдлийн өвслөг ургамлын дундаж өндөр нь 3.4 см. Эдгээр өсөлтөөс харахад тухайн ургамал бүлгэмдлийн өсөлт харьцангуй сул байгааг илэрхийлж байна. Бүлгэмдлийн эдификатор ургамал *Stipa krylovii*-крыловын Хялгана, *Cleistogenes squarrosa*-дэрвээн Хазаар өвс зэрэг зүйл ургамлууд харьцангуй давжаарсан байдалтай, цэцэглэж, үрлэж чадалгүйгээр хагдарсан. Зарим зүйл ургамал үрлэсэн боловч үр боловсрох оронд үр огт суугаагүй байдалтай хатсан байв. Ургац 162.4 кг.га, ургамалжлын аспект нь цайвар ногоон өнгийг үүсгэж байна.

Ховор ургамал ба бэлчээр тэжээлийн ач холбогдолтой ургамал. Судалгаа гүйцэтгэсэн талбайн эргэн тойронд ховор ургамал тэмдэглэгдээгүй. Бэлчээр тэжээлийн үнэт ургамал крыловын Хялгана, дэрвээн Хазаар өвс зэрэг ургамлууд тэмдэглэгдлээ.

3.7. АМЬТНЫ АЙМАГ

Амьтны аймгийн төлөв байдал

Улаанбаатар хот амьтны аймгийн хувьд орчимд шувуудаас оронгийн бор шувуу (*Passer domesticus*), хээрийн бор шувуу (*Passer montanus*), хөхвөр тагтаа (*Columba livia*), сохор элээ (*Milvus migrans*), алаг шаазгай (*Pica pica*), улаан хошуут (*Pyrhcorax pyrhcocorax*), хар хэрээ (*corvus corone*), хон хэрээ (*corvus corax*), зэрэг тохиолдоно. Хөхтөнөөс гэрийн хулгана нутагшина. Шавьжийн ангиас хатуу далавчтан буюу цохын баг(*coleoptera*) –жийгээ цохын овгийн (*carabidae*)-*taphoxenus laticollis*, *amara fodinoe*, *harpalus amplicollis*, арьс идэгч цохын овгийн(*dermestidae*)*dermestes dimidiatus*-няслуур цохын овгийн (*elateridae*)-*selatosomus latis*, мөлгөр цохын овгийн (*burprestidae*)- *sphenoptera canaercalata*, буглаа цохын овгийн-*epicauta megacephala*, *epicauta sibirica*, хайрсан далавчтаны багийн (*lepidotera*),дэнгийн эрвээхэй овгийн (*pyralidae*)-*prorophora albidogilvella*, сарьсан далавчтаны багийн шоргоолжны овгийн (*forimidae*)-*tetramorium caespitum*, сирфид ялааны овгийн (*syrphidae*)-*paragus haemorrhous*, махны ялааны овгийн (*sarcophagidae*)-*blaesoxiphella brevicorni*, *servaisia subamericana*, *serviasia ranfilovi* зүйлүүд тохиолддог. Тус төсөл хэрэгжиж буй орчмын нутаг дэвсгэр нь Улаанбаатар хотын эдэлбэр нутаг дэвсгэр учир амьтны аймгийн хувьд аль хэдийн нөлөөлөлд өртөж зүйлийн баялагаар тун ядмаг болсон байна. Түүнчлэн тухайн орчмын шувуудын зүйлийн баялагт тодорхой хэмжээний өөрчлөлт орж суурин газрын хүнд өөриймсөг–синотроп зүйлүүд илүүтэй үзэгдэх болсон байна.



БҮЛЭГ 4. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ЭРЧИМ

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Амгалан дулааны станцыг 1х116 МВт хүчин чадал бүхий зуухаар өргөтгөх төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг “Магадлан жагсаах” арга болон Матрицын аргаар тодорхойлов. Үүнд:

Байгаль орчны суурь үнэлгээ болон Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийн шаардлага болон манай орны нөхцөлд станцын үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийг ашиглахад гарч байсан урьд өмнөх ажлын туршлага, үйл ажиллагаа болон үйлдвэрлэлийн явцад гарч болох сөрөг нөлөөлөл, Дэлхийн банкнаас байгаль орчны үнэлгээний талаар 1991 онд гаргасан лавламж, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос гаргасан гарын авлага зэргийг ашигласан болно.

Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байгаа-байхгүй гэсэн зарчим дээр үндэслэдэг бөгөөд сөрөг нөлөөлөл байвал “х”-ээр, эерэг нөлөөг “+”-ээр тэмдэглэдэг. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь шууд, шууд бус, буцах ба буцалтгүй, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд урт, богино, эрчмийн хувьд ямар байхыг үзүүлдэг байна. Нөгөө нь төслийн байршил, технологийн шийдэлтэй холбоогүй төсөл хэрэгжих үеийн болзошгүй нөлөөлөл юм.

Хүснэгт 7. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал

№	Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зэрэг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
1. Байгалийн төрөл зүйн өөрчлөлт											
1	Газрын доорхи урсацын өөрчлөлт	-					-			-	
2	Газрын доорхи усны чанарын өөрчлөлт		-								
3	Газрын доорхи усны нөөц	-									-
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт		-								
4	Хөрсний элэгдэл, эвдрэл		-								
5	Геологийн тогтоцын өөрчлөлт										
6	Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт										
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		-								
2. Байгалийн нөөцийн ашиглалт											
8	Газрын гадаргын нөөц баялаг										
9	Бэлчээр, тэжээлийн байдал										
10	Эрдэс түүхий эд, нөөц		-							-	
11	Эрчим хүчний нөөц	+					+		+		+
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
12	Ундны усны чанар өөрчлөгдөх		-								
13	Ундны усны нөөц хомсдох		-								
14	Агаарын бохирдол		-								
15	Хөрсний бохирдол		-								
16	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		-								
17	Дуу, чимээ шуугианы нөлөөлөл		-								



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ “ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор												
18	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх											
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх		-			-	-		-			
20	Тусгай хамгаалалттай газар, нутаг нөлөөлөх											
21	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх											
22	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх											
5. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл												
23	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+		+		+		
24	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	+				+				+		
25	Хүн амын орлого нэмэгдэж өөрчлөгдөх	+				+		+		+		
26	Хүн амын тоо өөрчлөгдөх		+			+			+			
6. Эдийн засаг, байгаль орчин												
27	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх											
28	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+		+		
29	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+				+		+		+		
30	Ажлын байр нэмэгдэх	+				+		+		+		
31	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+				+			
32	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		+			+		+		+		
7. Бусад нөлөөлөл												
33	Шороон зам харилцаа, станцын машин механизмын хөдөлгөөн шилжилтээс үүдэх хөрсний эвдрэл	-				-		-	-			
34	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба грунтын усыг бохирдуулах.		-		-					-		
35	Ахуйн хог, хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	-			-			-				
36	Хүчтэй салхи, тоосжилт	-			-							
Нөлөөллийн тоо		Сөрөг	8	10	5	5	10	10	6	11	4	2
ширхэг		Эерэг	8	2	0	1	8	0	7	2	4	4

Тайлбар: +/- Эерэг нөлөөлөл
 -/- Сөрөг нөлөөлөл

Байгалийн экосистемийн өөрчлөлт: Станцын ашиглах тоног төхөөрөмжийн хүчин чадал их байх ба тухайн орон нутгийн байгаль-экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болон агаар орчин, усны нөөцөд шууд нөлөөлж, эдгээр нь урт хугацааны турш хүчтэй нөлөөлөлд хамрагдаж, ихэнхдээ буцалтгүй шинжтэй байна. Цахилгаан дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааны улмаас агаар орчныг бохирдуулагч хорт хий, тоос тоосонцор, дуу чимээ, усны уур үүсэх, үндсэн эх үүсвэр болох ус, нүүрсний нөөцөд үзүүлэх нөлөөлөл, улмаар хөрс ургамал, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг энд дурьдаж болох юм.

Байгаль орчны чанарын өөрчлөлт: “Амгалан дулааны станц” ТӨХК-ний Амгалан дулааны станцыг 1х116 МВт хүчин чадал бүхий зуухаар өргөтгөх төслийн үйл ажиллагаа нь агаар, хөрсөн бүрхэвчийн чанарт ихээр нөлөөлөх бөгөөд нөлөөллийн цар хүрээ дунд зэрэг, эрчим ихтэй, удаан хугацааны нөлөөлөл юм. Нөлөөллийн эх үүсвэр нь утааны яндан, бэлтгэл ус үйлдвэрлэх үеийн хаягдал ус зэрэг байна. Гэхдээ станцын нэвтрүүлж буй технологи, тоног төхөөрөмж нь байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бага байх боломжийг бүрдүүлж байна.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор: Станцын өргөтгөлийн үйл ажиллагаа нь одоогийн үйл ажиллагаа явуулж буй эзэмшлийн талбайд явагдах бөгөөд байгалийн өнгө төрхөнд





нэмж өөрчлөлт үзүүлэх, археологи, палентлогийн олдворт нөлөөлөх нөлөөлөл бага юм.

Эдийн засаг нийгмийн асуудал: Амгалан дулааны станцыг 1х116 МВт хүчин чадал бүхий зуухаар өргөтгөх төслийн үйл ажиллагаа нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах бөгөөд ажлын байр бий болж, иргэдийн амьжиргаанд тус нэмэр болох, дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх, тэдгээрийг даган бий болох эерэг нөлөөлөл ихтэй юм. Эдгээр нь шууд бөгөөд урт хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна.

4.2. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Төслийн хэрэгжилтийн үед агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь тоосжилт, зарим нэг төрлийн хий, эвгүй үнэр, усны уур, дуу шуугианы нөлөөлөл байх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь нөлөөллийг бууруулах зорилгоор ашиглалтын үед тээврийн замд усалгаа хийх, бетон хучилттай болгох, талбайн газар ашиглалтыг сайжруулах, хатуу хог хаягдлын тохижуулж байгаа нь сайшаалтай боловч цаашид үүсэж болзошгүй нөлөөллийг урьдчилан тооцон дүгнэн үзэхэд дараах байдалтай байна.

Агаар дахь тоосонцрын агууламж

Агаарт хатуу, шингэн төлөв байдалтай оршдог. 10 микрометрээс бага хэмжээтэй тоосны богино (1-24 цаг) ба урт хугацааны (хэдэн жилийн) нөлөөлөл нь уушги, зүрхний өвчлөл, нас баралтын нэг хүчин зүйл болдог. Зүрхний эсвэл уушгины өвчтэй хүмүүс, тухайлбал зүрхний архаг өвчтэй хүн, титэм судасны өвчтэй, гуурсан хоолойн багтраа өвчтэй хүн, өндөр настнууд (уушгины эсвэл зүрхний өвчингүй байж болно) тоосонд мэдрэмтгий байдаг. Зүрхний өвчтэй хүн тоосны нөлөөнд өртсөнөөс цээжээр хөндүүрлэх, чичрэх, амьсгал давхцах, сульдах, зүрхний хэмнэл алдагдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Тоос нь амьсгалын замын халдварт өвчний өртөмтгий байдлыг ихэсгэх бөгөөд амьсгалын замын архаг өвчнийг сэдэрэх нөлөөтэй. Стандарт хэмжээнээс хэтэрсэн агаар бохирдуулагч нь орчны ургамлан бүрхэвчийг доройтуулах, үзэгдэх орчныг багасгах, техник хэрэгслийг элэгдэлд оруулах, гэмтээх, хүмүүсийн эрүүл мэнд, хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөтэй. Тоосны бохирдлын нэг удаагийн хамгийн их хэмжээ 0.5 мг/м³-аас их бол хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлж эхэлдэг байна. Иймээс энэ хязгаарын утгыг зөвшөөрөх дээд хэмжээ гэж эрх бүхий байгууллагаас стандартчилж тогтоосон.

Нүүрсний тоос: Нүүрсийг Багануур болон Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнуудаас төмөр замаар тээвэрлэн, вагон хөмрөгчөөр хөмрөн суллаж, талбай руу зөөж хадгалдаг. Талбайд хадгалсан сийрэгжих, шинж чанараа алдах, бусад дамжлагуудаар зуух руу тээвэрлэх үед их хэмжээгээр тоосрох аюултай бөгөөд тоосонцрыг ус шүрших замаар, шаардлагатай бол бусад өөр аргаар багасгана. Дэгдэмхий тоосонцрыг хянахын тулд нүүрс хангах, хадгалах хэсгүүдэд нүүрсийг тэгш бус гадаргаар буюу жижиг овоолго үүсгэн хадгална.

Үнс зайлуулалтаас үүсэх тоосонцор: Хатуу түлшээр ажилладаг дулаан цахилгаан станцуудын зуухнуудын шаарга, үнс зайлуулах систем нь тасралтгүй найдвартай ажиллан шаталтын процессын үед гарсан үнс шааргыг агрегатын үйл ажиллагаанд нөлөөлөхгүйгээр зайлуулагдаж байхаар төлөвлөдөг. Хуурайгаар үнс зайлуулах энэхүү систем үнс, шааргатай хаягддаг дулааныг эргүүлэн ашиглах бололцоог бүрдүүлэхийн зэрэгцээ механик дутуу шаталтын алдагдал үүсгэж байгаа дутуу шатсан түлшийг дахин шатааснаар зуухны АҮК-ийг дээшлүүлэх бололцоо



бүрдүүлж, хүлэмжийн хийг бууруулахад онцгой үүрэг гүйцэтгэх давуу талтай байдаг.

Гэвч үнсэн сангийн ойролцоо, зонхилох салхины доод талд тархсан хөрсний гадарга дээр тогтсон үнс шиг өнгөтэй нунтаг шорооны механик бүрэлдэхүүн ялзмаг, карбонат, урвалын орчин, усан дахь хуурай үлдэгдлийн хэмжээ, үнсэн сангийн доторх шаартай үнсний тоон үзүүлэлттэй бараг адил байгаа нь үнсэн сан доторх шаартай үнс салхинд хийсч хөрс болон байгаль орчныг бохирдуулдагийг харуулж байна.

Усны уурын нөлөөлөл:

ДЦС-аас хүрээлэн буй орчинд хаягдаж байгаа бохирдуулагч зүйлийн нэг нь усны уур юм. Усны уур хүн, амьтан болон ургамлын ертөнцөд шууд нөлөө үзүүлэхгүй боловч манан үүсгэж, улмаар барилга байгууламж, зам талбайд мөсөн бүрхүүл тогтоож, цахилгаан дамжуулах шугаманд цан хөмрөг үүсгэхэд хүргэдэг. Түүнчлэн агаар мандалд хүхрийн исэлтэй нэгдэж хүхрийн хүчил болон фото химийн манан-**smog** үүсгэдэг. Аливаа гурван атомт хий нь хүлэмжийн хийг бүрэлдүүлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. ДЦС-аас хаягдаж байгаа усны уурын гол эх үүсгүүр нь техникийн ус хангамжийн систем юм.

Дуу шуугиан

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй дуу шуугиан нь маш хортой. Үүнийг анагаах ухаанд Шуугианы өвчин хэмээн нэрлэдэг. Энэхүү өвчин нь цусны даралт ихсэх, тамир тэнхээ муудах, толгой өвдөх зэрэг олон сөрөг нөлөө үзүүлнэ. Дуу шуугианы бохирдол нь хүнд хамгийн их стресс үүсгэдэг. Стресстэй хүн өвчинд нэрвэгдэх нь амархан. Хүний сонсголд инфра дуу маш муу нөлөөтэй. Инфрадуу дотоод чихэн дэхь тэнцвэрийн аппаратын үйл ажиллагааг өөрчилж чаддаг төдийгүй, 15-20Гц давтамж бүхий инфрадуу нь хүнийг айдаст автуулдаг байна. Шуугианы хэмжээ 80 децибелль байхад сонсголын мэдрэмж 17-25 децибеллээр буурч, хэлсэн үгний 20-25 хувийг нь сонсч чаддаггүй аж. Төв мэдрэлийн системийн далд урвал хэвийнхээс 30-40м/сек ихэсдэг бол 60 децибеллээс хэтрэх үед мэдээлэл дамжуулах хурд, ой тогтоолт эрс буурдаг байна. Түүнчлэн монголчуудын нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг зүрх судасны өвчлөл зүрхний импульс, артерийн даралт ихсэх багасах сөрөг тал бий. Тэр ч бүү хэл нойргүйдэх өвчлөлийн нэг үүсвэр гэдгийг эмч сэргэжилтнүүд анхааруулж буй. Шуугианы хэмжээ 40 децибелль байхад нойр алдагдаж улмаар 50 дицбелль хүрэхэд унтах хугацаа нэг цагаар багасаж гүн нойрсолт 62 хувь болтлоо буурдаг. Харин 35 децбиллээс бага үед нойр хэвийн, гүн нойрсолт 82 хувьд хүрдэг гэж эрүүл ахуйн үүднээс дүгнэсэн байх юм. Хүн нь 16-20000Гц давтамжтай дууны долгион хүлээн авдаг байна. Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй дуу чимээнээс болж хүн сонсох чадвараа алдаж байна. Чихэнд өөрчлөлт оруулах, дүлийрэх, хэнгэрэг цоорч, чихнээс цус гарах зэрэг өөрчлөлт ордог. Байнга мэдрэлд нөлөөлж ядраадаг.

Доргионы нөлөө

Өндөр далайцтай (0.5-0.003 мм-ийн) нам давтамж (3-100Гц) бүхий хэлбэлзлийг хүн доргио буюу чичиргээ хэлбэрээр хүлээж авдаг байна. Тоног төхөөрөмжийн доргио нь барилга байгууламжийн хийцийн эд анги, шал, газрын хөрсөөр дамжин хүний биед доргио үүсгэдэг.

Ялангуяа 6-9Гц-ийн давтамжтай хэлбэлзэл нь хүнд онцгой нөлөөлдөг. Учир нь



хүний бие, толгой, бүдүүн гэдэс зэрэг эрхтний хувийн хэлбэлзлийн давтамж нь 6-9Гц-тэй ойролцоо тул резонанс үүсч хүний бие дотоод эрхтний хэлбэлзэл (тэлэлт ба агшилт) эрс нэмэгдэж, онцгой аюултай нөлөө үзүүлдэг байна. Ер нь хэлбэлзэх хөдөлгөөний далайц хичнээн их байвал тархалтын энерги нь их, хүний биед үзүүлэх гаж нөлөө нь төдий чинээ өндөр байна. Мөн доргион үүсгэж, буцах давших хөдөлгөөн хийдэг пневматик багаж хэрэгсэл нь онцгой аюултай бөгөөд хүнийг салга болгодог байна.

Удаан хугацааны турш доргио, чичиргээнтэй орчинд ажилласан хүн салга өвчтэй болж хөдөлмөрийн чадвараа алдах, толгойн өвчтэй болох, нойргүйтэх, сэтгэл санаа уймарч уур уцаартай болох, үе мөчний өвчтэй болох, шөрмөс татах, булчин татах, биеийн тэжээлийн систем алдагдах зэрэг гаж нөлөөнд автагддаг байна.

Доргио чичиргээний удаан хугацааны нөлөөлөл нь барилга байгууламж хөшөө дурсгалын бөх батыг муутгаж эвдрэл, элэгдэлд хүргэж болохоос гадна үйлдвэрлэлийн технологийн процесст сөрөг нөлөө үзүүлж болох талтай юм.

Сонсголын босгоос өвчлөлтийн босго хүртэлх зайц (диапазон)-д дууны эрчим 10^{13} дахин ($10\text{Вт}/\text{м}^2:10^{-12}\text{Вт}/\text{м}^2=10^{13}$) ихэсдэг байна. Хүний чих дуу шуугианы үнэмлэхүй хэмжээг бус харин түүний өсөлт (өөрчлөлт)-ийн хэмжээг илүү хүлээн авдаг бөгөөд түүнийг дууны эрчмийн түвшин гэнэ. Дуу шуугианы өсөлт (өөрчлөлт)-ийн түвшинг Дб (децибел) заадаг. Өөрөөр хэлбэл шуугианы хэмжүүр 60 ДБА зааж байвал тухайн үйлдвэрийн шуугианы түвшин сонсголын босгоос 60 дахин их байгаа хэрэг бөгөөд 130 ДБА-д хүрвэл ажиллагсдыг шууд өвчлүүлэх хэмжээнд хүрч буй явдал юм.

4.3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

“Амгалан дулааны станц” ТӨХК нь Монгол орны гадаргын усны сүлжээний томоохон төлөөлөл Туул голын сав газрын дунд хэсэг, Туул голын баруун эргээс хойд зүгт 1.9 км зайд оршино. Судалгааны талбайн зүүн хэсэгт Туул голын цутгал гол болох Улиастайн гол орших бөгөөд хойноосоо урагш чиглэн урсаж Амгалан орчмоор Туул голд нийлнэ.

Урьд өмнө хийгдсэн судалгааны ажлаас үзэхэд Улиастайн голоос авсан усны дээжинд хийсэн шинжилгээнүүдээр Улиастайн голын усны эрдэсжилтээр жилийн агууламж 63-142,5мг/л-ийн хооронд хэлбэлзэж зуны хур борооны үед багасч (60,8мг/л), өвлийн гачиг үеийн сүүлээр ахин нэмэгдэж (142,5мг/л) ерөнхийдөө бага эрдэсжилттэй усанд хамаарагддаг байна. Голын усанд гидрокарбонатын ион, катионоос кальци-натрийн ион зонхилж усны хатуулаг, усны горимын өөрчлөлтөөс хамаарахгүй жилийн турш 0,59-1,23мг/л байдаг байна.

Судалгаанд хамрагдаж байгаа объект нь Улаанбаатар хотын зүүн хэсэгт, Туул голын цутгал гол Улиастайн голын 2-р дэнж, Туул голын хөндийн өргөгдсөн 3-р дэнжийн гадаргад байрлах бөгөөд геологийн тогтоц, гидрогеологийн энэ нөхцөлөөсөө шалтгаалан давхарга зүйн ангиллын хувьд 3 давхрага болгон ангилж байна. Үүнд:

- Орчин үеийн дөрөвдөгчийн аллювийн (aIQ_4) хурдасны уст үе.
- Орчин үе-дээд дөрөвдөгчийн аллювийн (aIQ_{3-4}) хурдасны уст үе.
- Дунд-дээд дөрөвдөгчийн аллювийн (aIQ_{2-3}) хурдасны уст үе гэж ангилж болно.



4.4. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙ, ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Төслийн талбай нь Туул голын цутгал Улиастайн голын баруун дэнж дээр оршино. Газрын гадаргын хэлбэр дүрсийн хувьд дундаж өндөртэй уулсын хоорондын тэгш ёроолтой хөндий, “Улиастай”-н голын дэнжийн системийг хамран оршино.

Судалгаанд хамрагдсан 10.7 га талбайд хээршмэл хүрэн болон голын хайрган хучаас дээр тогтворжсон үлдмэл нугархаг болон хээржүү хэв шинжийн цайвар хүрэн хөрс тархсан боловч хүний үйл ажиллагаа болон аж ахуйн үйл ажиллагааны нөлөөнөөс шалтгаалан хөрсөн бүрхэвч бүхэлдээ устан түүний оронд техноген гаралтай хөрс шорооны холимог битүү бүрхэж, тэдгээрт хөл газрын хог ургамал зонхилсон байна.

Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний хувьд судалгааны талбайд хөрсний эвдрэлийн үйл явц болон хүний үйл ажиллагааны нөлөөллийн улмаас хөрсний тогтвортой бүтэц алдагдан, гадарга дээр хөрс үүсгэгч эх чулуулаг ил гарсан байгаа бөгөөд элс: тоос:шаврын харьцаа 55:30:15 гэсэн хэмжээтэй байна. Хөрсний дээд А үед элс(2-0.05мм)-ийн хэсгийн хэмжээ 54% байгаа бол тоос(0.05-0.002мм)-ийн хэмжээ 29.3%, шаврын (< 0.002мм) -ийн хэмжээ 16.5% тус тус хэмжээтэй байна. Шилжилтийн АВ давхаргын хувьд элс(2-0.05мм)-ийн хэсгийн хэмжээ 58.6% байгаа бол тоос(0.05-0.002мм)-ийн хэмжээ 27.8%, шаврын (< 0.002мм) -ийн хэмжээ 13.6% байна. Хөрсний тогтвортой бүтэц үүсгэгч нарийн ширхэгт шаврын (< 0.002мм) -ийн хэмжээ 10%-иас их буюу шавранцар ангилалд багтана.

Хөрсний судалгаа гүйцэтгэсэн төслийн талбайн хойд хэсэгт ногоон байгууламж бүхий талбай зэрэг газруудад хөрсөн бүрхэвчтэй, бусад талбайг бетондсон учир хөрсний эвдрэл, бохирдолын төдийлөн нөлөө үзүүлэхгүй байх боломжтой.

4.5. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ

Төслийн талбай болон түүний ойр орчимд ургамлан нөмрөг хотжилттой холбоотойгоор ургамалталхагдалд өртөж, ургамлан нөмрөгийн унаган төрх алдагдах, шарилж, арзгар согсоолж мэтийн талхлагдлыг илэрхийлэгч ургамлаар солигдон устаж үгүй болох зэрэг төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт шууд нөлөөлөх үүсч болзошгүй юм.

Судалгаа гүйцэтгэсэн талбай нь уулын хээрийн бүсэд хамаарах 1 бүлгэмдлээс бүрдэнэ. Ургамалжлын зүйлийн хувьд 11 овгийн 14 төрлийн нийт 18 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд мод-1, олон наст өвс-13, хоёр наст-2, нэг наст-2 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв. Судалгаа гүйцэтгэсэн талбайн эргэн тойронд ховор ургамал тэмдэглэгдээгүй. Бэлчээр тэжээлийн үнэт ургамал крыловын Хялгана, дэрвээн Хазаар өвс зэрэг ургамлууд тэмдэглэгдлээ.

4.6. ТӨСЛӨӨС АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ

Улаанбаатар хот амьтны аймгийн хувьд орчимд шувуудаас оронгийн бор шувуу (*Passer domesticus*), хээрийн бор шувуу (*Passer montanus*), хөхвөр тагтаа (*Columba livia*), сохор элээ (*Milvus migrans*), алаг шаазгай (*Pica pica*), улаан хошуут (*Pyrhcorax pyrrhcorax*), хар хэрээ (*corvus corone*), хон хэрээ (*corvus corax*), зэрэг тохиолдоно. Хөхтөнөөс гэрийн хулгана нутагшина. Шавьжийн ангиас хатуу далавчтан буюу цохын баг(*coleoptera*) –жийгээ цохын овгийн (*carabidae*)-*taphoxenus laticollis*, *amara fodinoe*, *harpalus amplicollis*, арьс идэгч цохын овгийн(*dermestidae*)*dermestes dimidiatus*-няслуур цохын овгийн (*elateridae*)-*selatosomus latis*, мөлгөр цохын овгийн



(burprestidae)- sphenoptera canaercalata, буглаа цохын овгийн-epicauta megacephala, epicauta sibirica, хайрсан далавчтаны багийн (lepidotera),дэнгийн эрвээхэй овгийн (pyralidae)-prorophora albidogilvella, сарьсан далавчтаны багийн шоргоолжны овгийн (forimidae)-tetramorium caespitum, сирфид ялааны овгийн (syrphidae)-paragus haemorrhaus, махны ялааны овгийн (sarcophagidae)-blaesoxiphella brevicorni, servaisia subamericana, serviasia ranfilovi зүйлүүд тохиолддог. Тус төсөл хэрэгжиж буй орчмын нутаг дэвсгэр нь Улаанбаатар хотын эдэлбэр нутаг дэвсгэр учир амьтны аймгийн хувьд аль хэдийн нөлөөлөлд өртөж зүйлийн баялагаар тун ядмаг болсон байна. Иймээс тус төслийн зүгээс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна.

4.7. ТӨСЛӨӨС ОРШИН СУУГЧДАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Үйлдвэрийн үйл ажиллагаа нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах бөгөөд ажлын байр бий болж, малчин иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, арьс ширний дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх, тэдгээрийг даган бий болох эерэг нөлөөлөл ихтэй юм. Эдгээр нь шууд бөгөөд урт хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна.



БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Амгалан дулааны станц” ТӨХК-ний “Амгалан дулааны станцыг 1х116 МВт хүчин чадал бүхий зуухаар өргөтгөх” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОНХАЖ Сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны А-117 дугаар тушаал, БОНХСайдын 2014 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу холбогдох дүрэм журмын шаардлагад нийцүүлж боловсруулав.

Хүснэгт 8. БОМТөлөвлөгөөний зардлын задаргаа

№	Ажлын нэр	Зардал (мян.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	6 380.0
2	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	1 440.0
	Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал	7 820.0

5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хариуг үндэслэн жил бүр шинэчлэн, сайжруулж байх шаардлагатай юм.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2.1-д **“Төлөвлөгөөт аудитыг хоёр жил дутам, төлөвлөгөөт бус аудитыг Засаг дарга, эсхүл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудит хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хийнэ”** хэмээн заасны дагуу аж ахуйн нэгж өөрийн зардлаар аудит хийлгэнэ.

Байгаль орчин-эдийн засаг

“Амгалан дулааны станц” ТӨХК–ний дулааны цахилгаан станц нь улс орон болон бүс нутгийн ашиг орлого, дэд бүтцийн хөгжлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.

Улс орны төсөвт:

- Ашгийн татвар
- Хүн амын орлогын албан татвар
- АТӨЯХАТ
- Агаарын бохирдлын төлбөр
- Нийгмийн даатгалын шимтгэл зэрэг төлбөрүүдийг оруулна.
- Газар ашигласны төлбөр



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ “ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Ус ашигласны төлбөр ашиглахтай холбогдох татвар, төлбөрүүдийг оруулна.

Мөн байгаль орчныг хамгаалах зардлыг жил бүр үндсэн үйл ажиллагааны төсөвт тусгаснаар БОХТ ба БОХШХ-т тусгагдсан арга хэмжээнүүд бүрэн хэрэгжинэ.

Байгаль орчин-Удирдлага зохион байгуулалт: “Амгалан дулааны станц” ТӨХК-ний байгаль орчныг хариуцсан ажилтан БОХТ болон БОХШХ-ийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийн үр дүн болон дараагийн жилүүдэд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан тайланг компаний удирдлага болон байгаль орчин хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагад танилцуулах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны бодлого, зорилго: Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчинд онцгой анхаарал тавьж түүнд нөлөөлж болзошгүй аливаа нөлөөллийг багасгах үүрэгтэй. Үйл ажиллагаагаа явуулж эхлэхээс өмнө өөрийн албан хаагчид болон хамтран ажиллах бусад байгууллагыг байгаль орчин хамгаалах бодлогод хамруулахаар төлөвлөх хэрэгтэй. Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг багасгах, байгаль орчны талаарх дүрэм журмыг биелүүлэх зэргээр өөрсдийн бүх албан хаагчид, гэрээлэгчид өөрсдийн үүргийг биелүүлж ажиллахаар төлөвлөгөөндөө тусгасан байхыг зорино.

Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр: Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний байгаль орчин, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрт нь тодруулга хийн шинэчлэн тооцно.

Хүснэгт 9. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
1	Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1 580.0
2	Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	1 000.0
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	600.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	200.0
7	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	3 200.0
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал урьдчилсан байдлаар		6 380.0

5.2. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны үндсэн бүрдэл хэсгүүд (агаар, ус, хөрс, газрын гадарга, амьтан гэх мэт)–ээр төслийн үйл ажиллагааны хугацаанд биелүүлэх дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Төлөвлөгөөнд байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.





“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нөлөөллийг бууруулах төлөвлөгөөт арга хэмжээ	Нөлөөллийг бууруулах байгаль орчны бүрэлдэхүүн	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж
1.1	Сөөгнөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Хатуу хог хаягдлын цэгийг засаж тохижуулах, хур бороо орохооргүй таглаатай, ус хөрсөнд нэвчихээргүй суурьтай, салхинд ус ноос хийсэхээргүй хаалттай байх	Агаар, хөрс, ус	2023 онд
		Ахуйн хатуу хаягдал, түүхий эдийн ил задгай овоолгоос бохирдол хөрсөнд алдагдахаас сэргийлэх, үзлэг хяналт тавих, ХАБ, байгаль орчны чиглэлийн сургалтууддаа энэ чиглэлийн мэдээллийг оруулах	Хөрс, ус	2023 онд
		Үйлдвэрийн гадаад орчныг зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр хийгдэх арга хэмжээ(машин техникийн тээвэрлэлт хийх, түүхий эд материалыг ачиж буулгах талбайг тодорхой болгож тэмдэгжүүлэх, хөрсөнд бохирдол тархахааргүй болгож засаж янзлах, ашиглагдахгүй талбайд ажилчдын амарч, тухлах орчныг бий болгох)	Хөрс	2023 онд
		Хатуу хог хаягдлыг тусгай цэгт цуглуулах, гэрээлэгч компани зайлуултал тодорхой хяналт хийх	Хөрс, ус, агаар	2023 онд
		Эзэмшлийн талбайн 10%-тай тэнцэх талбайд ногоон байгууламж байгуулах	Хөрс, ус, агаар	2023 онд
		Ногоон байгууламжийн орчимд хаалт, хамгаалалт тавих	Хөрс	2023 онд
		Химийн бодис, түүхий эдийн агуулахын битүүмжлэлийг сайжруулах, хяналт, үзлэг тогтмол хийж хэвших, мэрэгч болон бусад амьтад нэвтрэх боломжийг бууруулах	Амьтан, ургамал	2023 онд
		Ноос, ноолуур боловсруулах технологиос гарч буй бохир усыг урьдчилан цэвэршүүлэх дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	Ус	2023 онд
		Агаар, хөрс, ус, ургамал, амьтан зэрэг байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нөхцөл байдал, чанарыг цогц байдлаар тодорхойлох хяналт шинжилгээ, судалгааны ажлыг хийлгүүлэн, зардлыг тухайн жилийн БОМТ-нд тусган төсөвлөх	Хөрс, ургамал, амьтан	2023 онд
		Гадаад орчны тоосжилтыг дарах зорилгоор усалгааг тогтмол хийж байх	Агаар	2023 онд
1.2	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Гадаад орчны усалгааны багаж хэрэгсэлтэй болох	Агаар	2023 онд
		Ажилчдад амны хаалт, хошуувч, маскыг тогтмол зүүлгэж хэвшүүлэх, хор тайлах бүтээгдэхүүнээр тогтмол хангах, тээврийн машинуудын кабины битүүмжлэлийг сайжруулах, хяналт шалгалт тогтмол хийх, ажилчдад сонсгол хамгаалах хэрэгсэл хэрэглүүлж хэвшүүлэх	Ажилчдын эрүүл мэнд, агаар	2023 онд
		Тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг тогтмол хийх	Агаар, хөрс	2023 онд
		Хатуу хог хаягдлыг ангилан хадгалах, зориулалтын саванд цуглуулах, хог хаягдлын цэгийг тохижуулах, ариутгал цэвэрлэгээг тогтмол хийх	Агаар, ус, хөрс	2023 онд
		Боловсруулах үйлдвэрийн цех, дамжлагуудын гэрэлтүүлэг, агааржуулалтыг жил бүр засаж, вентилятор суурилуулах, шаардлагатай өдрүүдэд агаар солилцоог нэмэгдүүлэх ажлуудыг хийж	Агаар	2023 онд
		Тоног төхөөрөмж, урьдчилан цэвэрлэх байгууламжийг хуваарийн дагуу цэвэрлэж, ариутгаж байх	Ус, хөрс, агаар	2023 онд
		Тээвэрт ашиглагдаж буй машин техник тоног төхөөрөмжөөс гарч буй хорт хийн хэмжээ стандарт шаардлагад нийцэж байгааг шалгах, стандартаас илүү хорт хий ялгаруулж буй машин техникийг засварлах, ашиглахгүй байх	Агаар	2023 онд



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Ногоон байгууламж байгуулсан талбайнуудад ургамлан нөмрөг ургах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор шимт бодисын агууламжийг нэмэгдүүлэх, бордох	Ургамал, хөрс	2023 онд
		Осол аваарь гарсан үед аймгийн байгаль орчны хяналтын газарт яаралтай мэдэгдэхийн зэрэгцээ түүнийг усан хангамжийн эх үүсвэр болгон ашиглаж байгаа хүний хэрэглээг хязгаарлах нь зүйтэй бөгөөд зайлшгүй шаардлагатай тохиолдолд тэднийг нүүлгэн шилжүүлэх, ус хангамжийн шинэ эх үүсвэр бий болгох, нөхөн төлбөр төлөх зэрэг арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлэх шаардлага үүссэн үед хэрэглэх мөнгөн хуримтлал үүсгэх	Агаар, ус, хөрс, ургамал, амьтан	2023 онд
1.3	Сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээ	Аваарь, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх, ажилчдад осол, аваарийн үед хэрэгжүүлэх ажил, үүргийн хуваарь гаргах, яаралтай үед ногоон байгууламжийг хорт утаа, тоосонцроос хамгаалах багаж хэрэгсэлтэй байх.	Агаар, ус, хөрс, ургамал, амьтан	2023 онд



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал	
АГААР							
Нүүрс хадгалалт, тээвэрлэлт, бутлуур цех, конвейер, зуухны яндан, тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөн, зам харгуй, ахуйн хог хаягдлын цэг зэргээс агаар дахь тоосжилт, PM, CO, SO ₂ , NO ₂ ихсэж орчны хүчилтөрөгчийн (O ₂) хэмжээ багасаж болно.	Дулааны цахилгаан станцын үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл болон утааны яндангаас гарах агаар бохирдуулагчдад тогтмол хэмжилт хийх замаар хяналт тавих, зөвшөөрсөн норм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолдлуудад дүгнэлт хийж шалтгааныг тогтоох, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх	Ашиглалтын хугацаанд	БОХШХ-т тусгав.		2023 он	MNS 4585:2007 Агаарын чанар. Ерөнхий шаардлага Монголын агаарын чанарын стандарт (MNS)-4585:98, MNS-3384:82, MNS-3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нэр томъёо, тодорхойлолт	
	Нүүрсний дамжуулах, хадгалах талбайн эргэн тойронд салхи тоосноос хамгаалах ургамал, ойн зурвас буй болгох замаар салхины хурд хүчийг сааруулах, өнгөн хөрсний шороо, тоос хийсэхийг багасгах	Ашиглалтын хугацаанд	500.0	500.0	2023 он		
	Хог хаягдлыг төслийн талбайн орчимд цуглуулалгүйгээр төвлөрсөн хогийн цэгт зайлуулах	Хог хаягдлын менежментэд тусгагдсан					
	Ахуйн хог хаягдал болон сэлбэг материалын хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын хогийн цэгт цуглуулах, хоёрдогч түхий эд болгож ашиглахаар ялгасан зүйлийг холбогдох цэг, үйлдвэрт тээвэрлэж хүргэх, борлуулах	Хог хаягдлын менежментэд тусгагдсан					
	Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц авахуулан шинжилгээ хийлгэж, зөвлөгөө авч байх	БОХШХ-т тусгагдсан.					
	Бохирдол ихтэй газар ажиллаж буй ажилчдад хувийн хамгаалах хэрэгслэлийг тараах, тогтмол хэрэглүүлж хэвшүүлэх	Дотоод төлөвлөлтөөр					
	Агаар бохирдуулагчид ихээр буй үүсч цех, дамжлагуудад агааржуулалтыг тогтмол хийж байх	Дотоод үйл ажиллагаагаар					
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРС, УРГАМАЛ							
Тээврийн хэрэгслийн явалт, ажилчдын хөлөөр хөрс эвдрэх, ургамал гэмтэх, эвдрэл үүсэхээс гадна шатах тослох материал, хог хаягдал,	Төслийн талбайн газар ашиглалтын мэдээллийг тодорхой болгох, газар ашиглалттай холбоотой бичиг баримтыг бүрдлийг хангах, эвдэгдсэн талбайн бүртгэл хөтлөх, онц шаарлагатайгаас бусад талбайд ашиглалт явуулахгүй байх арга хэмжээ авах	Дулааны цахилгаан станцын хэмжээнд	Дотоод төлөвлөтөөр		2023 он	УСТ 328-91 Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд	



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ “ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 1Х116 МВт ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ ЗУУХААР ӨРГӨТГӨХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсч болзошгүй	Дахин ашиглагдахгүй болсон талбайд тэмдэг тэмдэглэгээ байршуулж байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх	Дулааны цахилгаан станцын хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр		2023 он	MNS 5918-2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын ургамалжуулахад тавигдах шаардлага
